



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2015.05.07 № МХГ/1308

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000255001251

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“2.ХЭЛЭЛЦСЭН нь: Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

**2025. 04.15** № **01/2910**

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ -г

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
С.АМАРСАЙХАН ТАНАА**

Таны 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн ЗГ-2/345 тоот албан бичгээр ирүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000726



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.04.17 № 1/1979

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
С.АМАРСАЙХАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151301909  
A5.файл.2025



## **СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; гэж заасан.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050”<sup>1</sup> Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-ын 1 дүгээр үе шатны (2021-2030) 4-т “Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, Зорилт 4.4-ийн 2 дугаар үе шат (2021-2030)-ны 3-т “Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө. гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6.2-т “Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.”, 6.3-т “Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.” гэж, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.4.4-т “экспортыг дэмжих, худалдааг хөнгөвчлөхөд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор дэмжлэг үзүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” төлөвлөгөөний хүрээнд 1/Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Стандартчилал, хэмжил зүйн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд даалгасан.

Энэхүү харилцааг анх удаа зохицуулах зорилгоор 1994 онд Монгол Улсын Их хурлаас Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн бөгөөд, эдийн засаг, нийгмийн харилцааны онцлогт нийцүүлэн 2003 онд Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, 2017 онд Стандартчилал, техникийн

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 54 дүгээр тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхтгэл 2020 оны №25,

зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг тус тус батлан, мөрдүүлж иржээ.

Дээрхи хууль зүйн үндэслэл, шаардлага нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үндэслэл болно.

## **1.2.Практик шаардлага**

Өнөөгийн байдлаар Монгол Улсад 6525 стандарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд хүн, хуулийн этгээдээс стандартыг дагаж мөрдөхгүй үйл ажиллагаа эрхэлж, үйлчилгээ үзүүлдэгээс шалтгаалж хүний эрүүл мэнд хохирох, амьдрах орчин нөхцөл алдагдах зэрэг олон сөрөг үр дагаврууд гарсаар байна. Цаашид улс орон даяар бүхий л салбарт стандартыг дагаж мөрдөх, хэвшүүлэх зайлшгүй шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Орчин үед стандартгүй бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ гэж байхгүй бөгөөд энэ нь хүний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй салшгүй холбоотой юм.

Батлагдсан стандарт хэрэгжихгүй байгаа шалтгаан нь хяналт, зохицуулалт, зөвлөн туслах ажиллагаа хангалтгүй, үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгч этгээд заавал стандартын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ёстойгоо мэддэггүй зэргээс шалтгаалж байна.

Стандарт нь холбогдох хууль тогтоомжоор заавал дагаж мөрдөхөөр заагаагүй бол сайн дураар буюу үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь сонгон хэрэглэх баримт бичиг байдаг нь олон улсын практик юм. Гэвч стандартын талаарх тодорхойлолтод сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгжид төөрөгдөл, тодорхойгүй байдал үүсгэж байна. Тухайлбал, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу Засгийн газраас тохирлын үнэлгээнд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд стандартыг тодорхойлон заадаггүй нь хяналт шалгалтын нэгдмэл, ойлгомжтой байдлыг алдагдуулж байна.

Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор 644 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын үнэлгээнд заавал хамруулах шаардлагатай буюу холбогдох стандартуудад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх шаардлагыг тавьсан байна. Гэвч эдгээр заавал мөрдөх шаардлагатай стандартуудын хэрэгжилт практикт төдийлөн хангалтгүй байна. Тухайлбал, зөвхөн хүнсний бүтээгдэхүүнийг авч үзэхэд дотоодын 10 хувь, импортын 5 хувь, үйлчилгээний 70 хувьд стандартын баталгаажуулалтыг хийжээ.

Энэ нь төр хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүчин чадлын хувьд зах зээл дээр нийлүүлэгдэж байгаа тохирлын үнэлгээнд заавал хамрагдах ёстой бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд бүрэн хяналт тавих боломж сул байгаатай холбоотой. Түүнчлэн одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар стандартын хяналтыг мэргэжлийн хяналт болон гаалийн байгууллага л хэрэгжүүлэхээр заасан.

Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох боломж нээлттэй боловч хувийн хэвшлийн оролцоо, эрх хэмжээг нарийвчлан тодорхойлоогүйгээс гадна зөвхөн төрийн зүгээс тохирлын үнэлгээг хийсээр байгаа нь тохирлын үнэлгээнд хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог хангалттай хэмжээнд нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээг хөгжүүлэх, олон улсын түвшинд хүргэх боломжгүй байдалд хүргэж байна. Цаашид итгэмжлэлийн үйл ажиллагааны үр дүнд тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагааг төрөөс дэмжин ажиллах, зах зээлийн өрсөлдөөнийг бүрдүүлэх цаг үеийн шаардлага тулгарч байна.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх хариуцлагын арга хэмжээ хангалтгүй, дагаж мөрдөх стандартуудын талаарх төрийн хяналт, шалгалтын уялдаа холбоо сул, мөн тохирлын үнэлгээний итгэмжлэлийн харилцаанд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хангалтгүй, зах зээлд нийлүүлэгдэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаа эрсдэлтэй хэвээр байна.

Иймд стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтыг батлах, мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах процессыг хуулиар тусгайлан зохицуулах шаардлагатай гэж үзлээ.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

2.1.Монгол Улсын хөгжлийн баримт бичигт дурдсан стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулна.

2.2.Хуулийн төсөлд Монгол Улсын хэмжээнд дагаж мөрдөх стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, хэлэлцүүлэх, батлах үйл ажиллагааг тодорхой болгож, тус үйл ажиллагаанд төр, иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын буюу олон талт оролцоог нэмэгдүүлнэ. Тухайлбал, стандартыг тохирлын үнэлгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж байгааг өөрчилж төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын тэнцүү тооны төлөөлөл бүхий, салбаруудын эрдэмтэн, мэргэжилтэн, шинжээчдээс бүрдсэн Зөвлөл хэлэлцэж, батлахаар тусгана.

2.3.Хуулийн төсөлд хуулийн зорилт, зарчим, нэр томъёоны тодорхойлолт, стандартчилал, тохирлын үнэлгээний төрийн байгууллагын тогтолцоог тусгана. Түүнчлэн, стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн байгууллагын эрх, үүргийг нарийвчлан тодорхой заана.

2.4.Төрийн хяналт шалгалтаар заавал дагаж мөрдөх шаардлагатай стандартын тохирлын баталгаа, тохирлын үнэлгээг хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавих, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг тусгана.

2.5.Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах чиг үүргийг стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн байгууллага хариуцахаар, хяналт тавих чиг үүргийг салбарын хяналтын байгууллага хэрэгжүүлэхээр тусгана.

2.6.Хуулийн төсөлд стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон итгэмжлэлийн байгууллагын чиг үүргийг ялгамжтай тусгана.

2.7.Хуулийн төсөлд техникийн зохицуулалт, стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж,

стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас стандарт, техникийн зохицуулалт, баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, үйл ажиллагаандаа ашиглах; стандартчилал, тохирлын үнэлгээний санхүүжилтийн талаар тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар стандартыг хэрэгжүүлэх тогтолцоо боловсронгуй болж, олон улсын нийтлэг практикт нийцсэнээр дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг олон улсад зөвшөөрөх, гадаад худалдаа, экспортыг хөнгөвчлөх нөхцөл сайжирна.

Түүнчлэн стандартыг боловсруулж, батлахад төрийн чиг үүрэг, хуулийн этгээдийн оролцоо тодорхой болж, үйлдвэрлэгч, нийлүүлэгч стандартын хэрэгжилт хангагдана.

Төрөөс зөвшөөрөл олгох, төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд илүү хялбар буюу тавигдах үндсэн нөхцөл, шаардлагыг тохирлын баталгаанд үндэслэн хүлээн зөвшөөрөх тул төрийн албан хаагчид нөлөөлөх авлигын эрсдэлийг бууруулна.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

## СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-ын 1 дүгээр үе шат (2021-2030)-ны 4-т “Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.”, Зорилт 4.4-ийн 2 үе шат (2021-2030)-ны 3-т “Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Нэг Улс-Нэгдсэн стандарт” хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024-2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг боловсронгуй болгох” гэж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 159 дүгээр захирамжид Стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх талаар тус тус заасан.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжид стандартыг сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгж болон төрийн хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны хооронд үл ойлголцол бий болж тодорхойгүй байдал, ойлголтын зөрүү үүсгэж байна.

Монгол Улсад өнөөгийн байдлаар 6730 стандарт хүчин төгөлдөр байгаа ч тэдгээр стандартыг дагаж мөрдөхгүй байгаагаас шалтгаалан хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд сөрөг нөлөөллийг бий болгож, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна. Иймд цаашид стандартыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх, нийгэмд уг соёл, хандлагыг хэвшүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байна.

Монгол Улсын хөгжлийн баримт бичигт дурдсан стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн болоод хүн амын аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн 50-иас дээш хувьд өөрчлөлт орсон тул шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, үзэл баримтлалыг Монгол Улсын Шадар сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан.

Тус хуулийн төслийг 2022-2024 онд нийслэл, 21 аймгийн иргэд, аж ахуй нэгж, төр захиргааны байгууллага, мэргэжлийн холбоодын дунд 60 гаруй хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Мөн 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд “Стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин” хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулж, барилга, эрүүл мэнд, хүнс, хүрээлэн буй орчны стандартын

хэрэгжилт, эрх зүйн орчин сэдэвт хэлэлцүүлгийг салбар тус бүрд зохион байгуулж, 1000 гаруй оролцогчийг хамруулж, нэгдсэн хуралдаанаас санал, дүгнэлт гарган хуулийн төсөлд холбогдох саналыг тусгасан. Давхардсан тоогоор нийт 17,250 оролцогчийг хамруулж, саналыг тусгасан болно.

Хуулийн төсөл 8 бүлэг, 36 зүйлтэй ба дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэх зохицуулалтыг өөрчилж, стандартыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөхөөр;

- Хуулийн зорилт, зарчим, нэр томъёог шинэчилж, стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллага, түүний тогтолцоо, салбар дундын уялдааг хангах зохицуулалтыг бусад хуульд нийцүүлэн томъёолсон;

- Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актаар зохицуулж буй зарим харилцааг хуулийн төсөлд тусгаж, төрийн байгууллагын үйл ажиллагааны болон хяналт шалгалтын чиг үүрэг, энэхүү харилцаанд оролцогчдын эрх, үүргийг шинээр заасан;

- Монгол Улсын хэмжээнд дагаж мөрдөх стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, хэлэлцүүлэх, батлах үйл явцыг тодорхой болгож олон талын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарсан;

- Тохирлын үнэлгээний байгууллагуудыг бодлогоор дэмжих, эрх үүргийг тодорхой болгох, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн;

- Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг арилгах хүрээнд стандарт, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөхөөр зохицуулсан;

- Стандарт, техникийн зохицуулалтыг хэрэгжилтийн хяналтыг холбогдох эрх бүхий улсын байцаагч хэрэгжүүлэх, зах зээл дээрх болон Улсын хилээр орж ирж буй бараа бүтээгдэхүүн тохирлын баталгаатай эсэхэд хяналт тавих чиг үүргийг нарийвчлан тусгасан;

- Стандарт, тохирлын үнэлгээний чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлж ашиглах, тохирлын баталгаатайгаар улсын хилээр нэвтрүүлсэн бараа, бүтээгдэхүүний мэдээллийг төрийн байгууллага хооронд мэдээллийн сан үүсгэж ашиглах зохицуулалтыг шинээр нэмсэн;

- Чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд иргэн, хуулийн этгээдийн эрх үүргийг тодорхой зааж, стандартын хэрэгжилтэд зөвхөн төрөөс хяналт тавих бус иргэн, үйлдвэрлэгч, нийлүүлэгч бүх талын оролцоог хангахаар зохицуулсан;

- Сорьцын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төрийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих зэрэг олон талт хамтын ажиллагааны зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төслийг дагалдуулан "Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай", "Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай", "Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай", "Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай", "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай", "Хууль хүчингүй болсонд тооцох тухай", "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг

хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар стандартыг хэрэглэх, хэрэгжүүлэх тогтолцоо боловсронгуй болж, олон улсын нийтлэг жишигт нийцсэнээр дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг олон улсад зөвшөөрөх, гадаад худалдаа, экспортыг хөнгөвчлөх нөхцөл сайжирна. Түүнчлэн стандартын хэрэгжилт хангагдаж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдана.

---oOo---

## СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024-2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг боловсронгуй болгох” гэж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар 07-ны өдрийн 159 дүгээр захирамжид Стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх талаар, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийт 33 салбар, үйл ажиллагаанд шинэ стандарт нэвтрүүлэхээр тус тус заасан.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-ын 1 дүгээр үе шат (2021-2030)-ны 4-т “Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.”, Зорилт 4.4-ийн 2 үе шат (2021-2030)-ны 3-т “Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нэг Улс-Нэгдсэн стандарт” хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж, мөн 33 салбар, үйл ажиллагаанд шинээр стандарт нэвтрүүлэхээр заасан.

Монгол Улсад өнөөгийн байдлаар 2017 онд батлагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, тухайн салбарт стандартыг батлан хэрэгжүүлэхээр заасан 71 хууль, нийт 6733 стандарт хэрэгжиж байгаа ч түүнийг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөхгүй байгаагаас шалтгаалан хүн, амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдаж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна.

Монгол Улсын Шадар сайдын тушаалаар 2022 онд барилга, эрүүл мэнд, хүнс, аялал жуулчлалын салбарын 2000 гаруй стандартад үзлэг хийж олон улсын жишигт нийцсэн эсэхийг судлахад 782 стандартыг хэвээр, 159 стандартыг хүчингүй болгох, 1067 стандартыг олон улс, бүс нутгийн жишигт нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

Дүгнэлт гарснаас хойш 3 жилийн хугацаа өнгөрөхөд 204 стандарт буюу үзлэгт хамрагдсан стандартын өөрчилбөл зохих нийт стандартын 20 хүрэхгүй хувийг шинэчлэн баталж, үлдсэн 80 орчим хувийг шинэчлээгүй өнөөдрийг хүрчээ. Энэ нь эрүүл мэнд, барилга, хүнс, аялал жуулчлалын салбар дэлхийн хөгжил дэвшил, технологи, инновацаас хоцорч, дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, худалдаан дахь саад тотгорыг арилгахад сөргөөр нөлөөлж байна.

Тохирлын үнэлгээний итгэмжлэлд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд нөлөөлөхүйц бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ хамрагдахгүй байгаа нь нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тухайлбал, эрүүл мэндийн чиглэлийн төр, хувийн хэвшлийн 400 орчим лаборатори үйл ажиллагаа явуулж байгаагаас 35 лаборатори стандартын үзүүлэлт шаардлагыг хангаж итгэмжлэгдсэн байна.

Мөн хүнсний чиглэлийн төр, хувийн хэвшлийн 114 лаборатори үйл ажиллагаа явуулж байгаагаас 35 хувь нь итгэмжлэгдээгүй, худалдаалагдаж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг (эмийн болон пестицидийн үлдэгдэл, микотоксин, хүнд металл болон бусад бохирдуулагчид) бүрэн шинжилж чадахгүй байгаа нь хүнсний аюулгүй байдал алдагдах түвшинд хүрч, хүнсээр дамжих өвчлөлийн тохиолдлын тоо ихсэж улмаар хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх болсныг харуулж байна.

Стандартын хэрэгжилтийг мөрдүүлэх, хянах тогтолцооны нэг хэсэг нь лаборатори боловч өнөөгийн байдлаар үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сорилтын лабораториудын барилга, байгууламж, хүчин чадал, тоног төхөөрөмж, урвалж бодисын хангалт, хүний нөөцийн чадавх муу байгаагаас бүх салбарын лабораторийн бодлого, тогтолцоо алдагдаж, стандартын хэрэгжилтийг хангах, хянах боломжгүйд хүрчээ.

Монгол Улсад анх Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг 1994 онд, Стандартчилал, тохирлын үнэлгээний хууль 2003 онд, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг 2017 онд УИХ-аас тус тус баталжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 159 дүгээр захирамжийн хүрээнд Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 80 дугаар тушаалаар стандартчиллын эрх зүйн орчныг шинэчлэх чиг үүрэг бүхий Ажлын дэд хэсэг байгуулагдсан.

Тус Ажлын дэд хэсгээс нийслэл, 21 аймгийн иргэд, аж ахуй нэгж, төр захиргааны байгууллага, мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулсан 60 гаруй хэлэлцүүлгийн үр дүн болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээний дүгнэлтээр энэ хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.

Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 оноос хойш боловсруулж холбогдох яамдаас 2 удаа албан ёсоор санал авч, Үндэсний хэмжээнд нэгдсэн хэлэлцүүлэг 3 удаа, салбарын хэмжээнд 60 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 17,000 мянга гаруй оролцогчийг хамруулж, саналыг тусгасан.

Цаашид стандартыг дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар стандартыг хэрэгжүүлдэг соёл хандлагыг төлөвшүүлэх, үндэсний хяналт, зохицуулалтын тогтолцоог бий болгох шаардлагатай гэж Ажлын хэсэг, мэргэжлийн оролцогчид, эрдэмтэн судлаачид дүгнэсэн.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн 50-иас дээш хувьд өөрчлөлт орсон тул шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, үзэл баримтлалыг Монгол Улсын Шадар сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан.

Энэхүү хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээгээр стандартын хөгжлийн сан, стандартын байгууллагын ажилтны нийгмийн баталгаа зэрэг нь бусад хууль тогтоомжтой давхардаж байх, зарим харилцаа буюу итгэмжлэлийн үйл ажиллагаа, шинжээчийн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлд хамаарах Зөвшөөрлийн тухай

хуулиар зохицуулах шаардлагатай харилцаа гэж дүгнэснийг Ажлын хэсэг тус тус хэлэлцэн ихэнх саналыг хүлээн авч хуулийн төслийг ахин сайжруулсан болно. Ингэхдээ оролцогч талуудын эрх үүргийг тодорхой болгох замаар стандартын хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарсан.

Хуулийн төсөл 8 бүлэг, 36 зүйлтэй ба иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэх зохицуулалтыг өөрчилж, стандартыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөхөөр заасан. Стандартаар дамжуулан салбарын үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог бий болгоход хуулийн төслийн гол үзэл баримтлал чиглэж байна.

Стандарт, техникийн зохицуулалтыг дагаж мөрдөх, бүтээгдэхүүн, үйлчилгээг баталгаажуулалтад хамруулах, худалдаан дахь тарифын бус саад тотгорыг арилгах хэм хэмжээ бүхий хуулийн төслийг хэлэлцэн батлагдсанаар стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллага, түүний хяналт зохицуулалтын тогтолцоо бүрдэж, салбар дундын уялдаа хангагдаж, иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдэнэ.

Түүнчлэн олон улсын болон бүс нутгийн стандартыг хүлээн зөвшөөрөх, хэрэглэх, нутагшуулж, стандартыг хэрэгжүүлэх хяналт, зохицуулалтын тогтолцоо боловсронгуй болсноор дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандарт олон улсад зөвшөөрөгдөж, гадаад худалдаа, экспортыг хөнгөвчлөх нөхцөл сайжирна гэж үзэж байна.

Энэ хуулийн төсөл батлагдсанаар экспорт, импортын барааг тохирлын үнэлгээний байгууллагын тохирлын гэрчилгээ, нотолгоонд үндэслэх байдал дээшилнэ, улмаар тохирлын баталгаатай бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх нөхцөл хангадан, дотоодын бүтээгдэхүүн олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ гэж тооцоолж байна.

Дэлхийн улс орнууд стандартын цахимжуулалт, дижитал шилжилтийн дараагийн асуудал хиймэл оюун ухаан руу шилжиж цаг үе биднийг хөл нийлүүлэн алхахыг шаардаж байна. Стандарт, хэмжил зүйн салбар сүүлийн нэг жилийн хугацаанд 26 ажил үйлчилгээг цахимжуулсан бөгөөд цахимжилт, мэдээллийн сангийн эрх зүйн зохицуулалтыг мөн хуулийн төсөлд тусгасан.

Стандарт, тохирлын үнэлгээний салбарт цахимжуулалт, мэдээллийн санг нэвтрүүлснээр энэхүү үйл ажиллагаанд оролцогчид мэдээллийн санд мэдээлэл оруулах, мэдээллийг харилцан ашиглах байдлыг нэмэгдүүлж, хил, гааль, төрийн хяналт шалгалтын салбарт мэдээллийн санд үндэслэсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэхээр зорьж байна.

Монгол Улс нь стандарт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн үйл ажиллагааг цахимжуулснаар хил гаалийн мэдээлэл, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг хилийн хорио цээрийн хяналттай нэвтрүүлэх, төрийн үйлчилгээ хялбарших, улмаар авлигын эрсдэлийг бууруулах боломж бүрдэх юм.

Цаашид стандарт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн үйл ажиллагаагаар дамжуулан салбар, салбарын шилдэг технологи, инновацийн шинэчлэлтийг нэвтрүүлж, хяналт зохицуулалтын тогтолцоог сайжруулж, иргэдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, гадаад, дотоод худалдааны эргэлтийг сайжруулж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд голлох хувь нэмрийг оруулах учиртай.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах гол зохицуулалтыг тусгасан болно. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэх зохицуулалтыг өөрчилж, стандартыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөхөөр;

- Хуулийн зорилт, зарчим, нэр томъёог шинэчилж, стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллага, түүний тогтолцоо, салбар дундын уялдааг хангах зохицуулалтыг бусад хуульд нийцүүлэн томъёолсон;

- Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актаар зохицуулж буй зарим харилцааг хуулийн төсөлд тусгаж, төрийн байгууллагын үйл ажиллагааны болон хяналт шалгалтын чиг үүрэг, энэхүү харилцаанд оролцогчдын эрх, үүргийг шинээр заасан;

- Монгол Улсын хэмжээнд дагаж мөрдөх стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, хэлэлцүүлэх, батлах үйл явцыг тодорхой болгож олон талын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарсан;

- Стандартын хэрэгжилтийг тодорхой хугацаанд үнэлж дүгнэх, стандартын баримт бичигт давтамжтай үзлэг хийх цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, сайжруулах талаар зохицуулсан;

- Тохирлын үнэлгээний байгууллагуудыг бодлогоор дэмжих, эрх үүргийг тодорхой болгох, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээний үр дүнг ашиглах, хүлээн зөвшөөрөхөд чиглэсэн;

- Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг арилгах хүрээнд стандарт, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөхөөр зохицуулсан;

- Стандарт, техникийн зохицуулалтыг хэрэгжилтийн хяналтыг холбогдох эрх бүхий улсын байцаагч хэрэгжүүлэх, зах зээл дээрх болон Улсын хилээр орж ирж буй бараа бүтээгдэхүүн тохирлын баталгаатай эсэхэд хяналт тавих чиг үүргийг нарийвчлан тусгасан;

- Стандарт, тохирлын үнэлгээний чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлж ашиглах, тохирлын баталгаатайгаар улсын хилээр нэвтрүүлсэн бараа, бүтээгдэхүүний мэдээллийг төрийн байгууллага хооронд мэдээллийн сан үүсгэж ашиглах зохицуулалтыг шинээр нэмсэн;

- Чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд иргэн, хуулийн этгээдийн эрх үүргийг тодорхой зааж, стандартын хэрэгжилтэд зөвхөн төрөөс хяналт тавих бус иргэн, үйлдвэрлэгч, нийлүүлэгч бүх талын оролцоог хангахаар зохицуулсан;

- Сорьцын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгаж, төрийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих зэрэг олон талт хамтын ажиллагааны зохицуулалтыг тусгасан;

- Стандартын байгууллагын орон нутгийн нэгжийн чиг үүргийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан;

Хуулийн төслийг дагалдуулан “Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай” “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай”, “Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Хууль хүчингүй болсонд тооцох тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар стандартыг хэрэглэх, хэрэгжүүлэх тогтолцоо боловсронгуй болж, олон улсын нийтлэг жишигт нийцсэнээр дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг олон улсад зөвшөөрөх, гадаад худалдаа, экспортыг хөнгөвчлөх нөхцөл сайжирна. Түүнчлэн стандартын хэрэгжилт хангагдаж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдана.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ

(Шинэчилсэн найруулга)

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомж

2.1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зарчим

3.1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

3.1.1.хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангасан байх;

3.1.2.бие даасан, хараат бус байх;

3.1.3.сонирхогч талуудын оролцоог тэгш хангасан байх;

3.1.4.барим т нотолгоо, шинжлэх ухаан, дэвшилтэт технологи, инновацид суурилсан байх;

3.1.5.үйлдвэрлэл, худалдаанд хуульд заасан үндэслэл, журмаас гадуур аливаа хэлбэрээр саад учруулахгүй байх;

##### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."стандартчилал" гэж бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг;

4.1.2."стандарт" гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж, баталсан, дагаж мөрдөх баримт бичгийг;

4.1.3."техникийн зохицуулалт" гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг;

4.1.4."тохирлын үнэлгээ" гэж стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг;

4.1.5."тохирлын үнэлгээний байгууллага" гэж энэ хуулийн 4.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх байгууллагыг;

4.1.6."баталгаажуулалт" гэж бүтээгдэхүүн, тогтолцоо нь тогтоосон шаардлагад нийцэж байгааг эрх бүхий хөндлөнгийн байгууллагын нотлох ажиллагааг;

4.1.7."тохирлын баталгаа" гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцэж байгааг нотлох тохирлын гэрчилгээ, нийлүүлэгчийн мэдэгдлийг;

4.1.8."тохирлын гэрчилгээ" гэж бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгааг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.9."нийлүүлэгчийн мэдэгдэл" гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа талаар үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчээс бичгээр гаргасан нотолгоог;

4.1.10."тохирлын тэмдэг" гэж бүтээгдэхүүн нь стандартын шаардлагыг хангаж байгааг тодорхойлсон тэмдэглэгээг;

4.1.11."аюулгүйн тэмдэг" гэж бүтээгдэхүүн нь техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгааг тодорхойлсон тэмдэглэгээг;

4.1.12."баталгаажуулалтын схем" гэж тохирлын үнэлгээнд хамрагдах зүйлийг тодорхойлж, үнэлэх аргачлалыг;

4.1.13."тохирлын үнэлгээний итгэмжлэл" гэж эрх бүхий байгууллагаас тохирлын үнэлгээний үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн чадавхитайг тогтоох ажиллагааг;

4.1.14."сорилт" гэж стандарт, арга аргачлалын дагуу бүтээгдэхүүний үзүүлэлтийг тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.15. "бүтээгдэхүүн" гэж үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцад бий болсон үр дүнг;

4.2. Энэ хуулийн 4.1-д зааснаас бусад нэр томъёог Монгол Улсын хууль, олон улсын стандартчиллын байгууллагаас баталсан стандарт, удирдамжид заасны дагуу ойлгож хэрэглэнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **5 дугаар зүйл. Техникийн зохицуулалт**

5.1. Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор техникийн зохицуулалтыг нийтээр заавал дагаж мөрдөнө.

5.2. Техникийн зохицуулалтыг төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, энэ хуулийн 5.3-т заасан дүгнэлтийг үндэслэн Засгийн газар батална.

5.3. Техникийн зохицуулалт боловсруулах аргачлалыг стандартаар тогтоох бөгөөд аргачлалын дагуу боловсруулсан эсэхийг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага хянаж, дүгнэлт гаргана.

5.4. Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг улсын хэмжээнд Засгийн газар болон Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан эрх бүхий байгууллага хангуулна.

5.5. Монгол Улсаас гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг батлагдахаас 60-аас доошгүй хоногийн өмнө стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад мэдээлнэ.

5.6. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудаас санал болгож байгаа гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

5.7. Зөвшөөрөл эзэмшигч энэ хуульд заасан техникийн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно.

### **6 дугаар зүйл. Стандартчиллын зорилго, баримт бичиг**

6.1. Стандартчиллын зорилго нь бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал болон сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

6.2. Стандартчиллын баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:

6.2.1. Монгол Улсын /цаашид "үндэсний" гэх/ стандарт;

6.2.2.хотын стандарт;  
6.2.3.байгууллагын стандарт;  
6.2.4.олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, гадаад улсын стандарт.

6.3.Стандартчиллын баримт бичиг зохиогчийн эрхэд хамаарахгүй.

## **7 дугаар зүйл.Үндэсний стандарт**

7.1.Үндэсний стандартыг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага батална.

7.2.Үндэсний стандарт нь олон улс, бүс нутгийн стандартын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.

7.3.Үндэсний стандартын төслийг сонирхогч талууд зөвшилцлийн үндсэн дээр санаачлан боловсруулна.

7.4.Үндэсний стандарт нь товчилсон тэмдэглэгээ, улсын бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол стандартчиллын баримт бичгийн мэдээллийн санд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7.5.Бусад хуульд стандартыг баталж, мөрдүүлэхээр заасан бол бүртгүүлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

## **8 дугаар зүйл.Хотын стандарт**

8.1.Хотын удирдлагаас хуульд заасны дагуу хотын стандартыг батлан хэрэглэнэ.

8.2.Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.

## **9 дүгээр зүйл.Байгууллагын стандарт**

9.1.Хуулийн этгээд нь байгууллагын стандартыг боловсруулан үйл ажиллагаандаа хэрэглэж болно.

9.2.Байгууллагын стандарт нь үндэсний болон олон улс, бүс нутаг, гадаад улсын стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн байна.

9.3.Байгууллагын стандартыг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага, түүний харьяа аймаг, нийслэл дэх байгууллагад бүртгүүлнэ.

## **10 дугаар зүйл.Олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, гадаад улсын стандарт**

10.1.Иргэн, хуулийн этгээд нь олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, гадаад улсын стандартыг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэж болно.

10.2. Олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, гадаад улсын стандартыг бүртгүүлэн хэрэглэх хугацаа 18 сар хүртэл байна.

10.3.Иргэн, хуулийн этгээд нь энэ хуулийн 10.1-д заасны дагуу бүртгүүлэн хэрэглэж байгаа Стандартчиллын баримт бичгийг энэ хуулийн 10.2-т заасан хугацаанд үндэсний стандартаар батлуулна.

## **11 дүгээр зүйл.Стандартчиллын техникийн хороо**

11.1.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагын дэргэд салбарын харьяаллаар үндэсний болон олон улс, бүс нутгийн, хотын стандартын төслийг хэлэлцэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус Стандартчиллын техникийн хороо /цаашид "Техникийн хороо" гэх/ ажиллана.

11.2.Шаардлагатай гэж үзвэл тодорхой чиглэлээр Техникийн дэд хороог байгуулан ажиллуулж болно.

11.3.Техникийн хороо, дэд хороо нь төрийн байгууллага, тухайн салбарын мэргэжлийн холбоод, хуулийн этгээд, шинжлэх ухааны байгууллагын төлөөлөл болон сонирхогч бусад талуудын төлөөлөл бүхий 15 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

11.4.Техникийн хороо, дэд хороо нь дараах эрх, үүрэгтэй:

11.4.1.үндэсний болон олон улс, бүс нутгийн стандартын төслийг хэлэлцэх, санал өгөх, дүгнэлт гаргах;

11.4.2.стандартын төсөлд холбогдох байгууллагын санал авах, сонирхогч талуудтай зөвшилцөх;

11.4.3.хүчин төгөлдөр стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

11.4.4.стандартын боловсруулалтын түвшин, агуулга зохих шаардлагад нийцсэн эсэхийг хянах.

11.5.Техникийн хороо, дэд хорооны гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй байна.

## **12 дугаар зүйл.Стандартыг мөрдөх, хэрэглэх**

12.1.Иргэн, хуулийн этгээд стандартыг дагаж мөрдөнө.

12.2.Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандарт нь тухайн баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна.

12.3.Үндэсний болон олон улс, бүс нутаг, гадаад улсын стандартыг хувиран олшруулахыг хориглоно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ**

### **13 дугаар зүйл.Тохирлын үнэлгээний зорилго, хамрах хүрээ**

13.1.Бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах зорилгоор тохирлын үнэлгээнд хамруулна.

13.2.Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд заавал хамруулна.

13.3.Тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүний жагсаалтыг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

13.4.Менежментийн тогтолцоо болон тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгчийн хүсэлтээр тохирлын үнэлгээнд хамруулж болно.

### **14 дүгээр зүйл.Тохирлын баталгаа**

14.1.Тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна.

14.2.Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага хүлээн зөвшөөрнө.

14.3.Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсад болон Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон улс орнуудад хүчин төгөлдөр байна.

14.4.Нийлүүлэгчийн мэдэгдэлд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

14.5.Нийлүүлэгчийн мэдэгдлийг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагад бүртгүүлнэ.

14.6.Экспортын бүтээгдэхүүнд стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллага тохирлын гэрчилгээ олгоно.

14.7.Тохирлын болон аюулгүйн тэмдэг, түүнд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

14.8.Тохирлын тэмдгийг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага, аюулгүйн тэмдгийг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага олгоно.

### **15 угаар зүйл.Тохирлын үнэлгээний байгууллагын эрх, үүрэг**

15.1.Тохирлын үнэлгээний байгууллагад дараах байгууллага хамаарна:

15.1.1.баталгаажуулалтын байгууллага;

15.1.2.лаборатори;

15.1.3.техникийн хяналтын байгууллага.

15.2.Тохирлын үнэлгээний байгууллага нь Монгол Улсын хуулийн этгээд байх бөгөөд холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу үйл ажиллагаа явуулна.

15.3.Тохирлын үнэлгээний байгууллага нь итгэмжлэлд хамрагдаж болно.

15.4.Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага тохирлын үнэлгээ хийнэ.

15.5.Гадаад улсын итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн болон гадаад улсын тохирлын үнэлгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тохирлын үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх бол энэ хуульд заасан итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагад бүртгүүлнэ.

15.6.Энэ зүйлийн 15.5-д заасны дагуу бүртгүүлээгүй гадаад улсын тохирлын үнэлгээний байгууллагын үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй.

15.7.Тохирлын үнэлгээний байгууллага дараах эрх, үүрэгтэй:

15.7.1.тохирлын үнэлгээний үр дүнг үндэслэн тайлан, дүгнэлт гаргах, тохирлын гэрчилгээ олгох, хүчингүй болгох;

15.7.2.тохирлын үнэлгээг итгэмжлэлээр тогтоосон хүрээнд явуулах;

15.7.3.итгэмжлэлийн шалгуурыг тогтвортой хангах;

15.7.4.тохирлын үнэлгээний ажилд холбогдох мэргэжилтнийг татан оролцуулах;

15.7.5.тохирлын үнэлгээний дүн, илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх.

## **16 дугаар зүйл.Баталгаажуулалтын байгууллага**

16.1.Баталгаажуулалтын байгууллага нь бүтээгдэхүүний, менежментийн тогтолцооны, ажилтны гэсэн төрөлтэй байна.

16.2.Баталгаажуулалтын байгууллага нь тохирлын үнэлгээг схемийн дагуу гүйцэтгэнэ.

16.3.Баталгаажуулалтын шинжээчид тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

16.4.Баталгаажуулалтын үйл ажиллагааг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагаас эрх авсан баталгаажуулалтын шинжээч гүйцэтгэнэ.

16.5.Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлэгдсэн сорилт, туршилтын лаборатори, техникийн хяналтын байгууллагын үр дүнг ашиглана.

16.6.Тохирлын үнэлгээний үр дүнгээр тохирлын гэрчилгээг хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

## **17 дугаар зүйл.Лаборатори**

17.1.Лаборатори нь сорилт туршилтын, шалгалт тохируулгын, эмнэлгийн, техникийн оношилгооны гэсэн төрөлтэй байна.

17.2.Лаборатори нь стандарт, арга аргачлалын дагуу үйл ажиллагааг явуулж, үр дүнг бие даасан, хараат бусаар гаргана.

17.3.Лаборатори нь стандартын шаардлагыг хангахуйц нөөц, чадавхтай байна.

### **18 дугаар зүйл.Техникийн хяналтын байгууллага**

18.1.Техникийн хяналт нь үйлдвэрлэгчийн, импортлогчийн, хөндлөнгийн гэсэн төрөлтэй байна.

18.2.Техникийн хяналтын байгууллага нь бүтээгдэхүүн, түүний зохион бүтээлт, үйлдвэрлэл, ажил үйлчилгээ, ажлын байрны орчин нөхцөл, хэвийн ажиллагаа, аюулгүй байдлын үзүүлэлт нь стандартаар тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛ**

#### **19 дүгээр зүйл.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго, тогтолцоо**

19.1.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго нь худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутгийн болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

19.2.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоо нь итгэмжлэлийн байгууллага, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага, итгэмжлэлийн техникийн хороо, итгэмжлэлийн шинжээчээс бүрдэнэ.

#### **20 дугаар зүйл.Итгэмжлэлийн байгууллага**

20.1.Итгэмжлэлийн байгууллага нь тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.

20.2.Итгэмжлэлийн байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

20.3.Итгэмжлэлийн байгууллага нь итгэмжлэлийг эрхлэн хэрэгжүүлэх бөгөөд дараах бүрэн эрхтэй:

20.3.1.тохирлын үнэлгээний байгууллагын тодорхой үйл ажиллагаа явуулах чадавхыг тогтоож итгэмжлэх, сунгах, хүчингүй болгох;

20.3.2.итгэмжлэлийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах;

20.3.3.холбогдох дүрэм, журам, заавар батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

20.3.4.олон улс, бүс нутгийн байгууллага, гадаад улстай итгэмжлэлийн үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх, хэлэлцээрт нэгдэх, олон улсын байгууллагад гишүүнээр элсэх санал гаргах;

20.3.5.олон улс, бүс нутаг, гадаад улсын итгэмжлэлийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

20.3.6.эрхэлсэн асуудлаар сургалт, судалгаа явуулах;

20.3.7.тохирлын үнэлгээний итгэмжлэлийн шинжээчид эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох.

## **21 дүгээр зүйл.Итгэмжлэлийн техникийн хороо, шинжээч**

21.1.Итгэмжлэлийн техникийн хороо нь итгэмжлэлийн шалгуур тогтоох, тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн шаардлага, шалгуурыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргаж, зөвлөгөө өгнө.

21.2.Итгэмжлэлийн техникийн хороо нь орон тооны бус байх бөгөөд сонирхогч талуудын оролцоог тэгш хангасан байна.

21.3.Итгэмжлэлийн шинжээч нь тохирлын үнэлгээний байгууллагын чадавх хууль болон стандарт, техникийн зохицуулалтын шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг үнэлж, дүгнэлт гаргана.

21.4.Итгэмжлэлийн шинжээчид тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

21.5.Итгэмжлэлийн шинжээч нь үнэлгээний дүнг итгэмжлэлийн байгууллагад тайлагнана.

## **ТАВДУГААР БҮЛЭГ СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА**

**22 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаар Засгийн газрын бүрэн эрх**

22.1.Засгийн газар стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

22.1.2.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцооны үр нөлөөг сайжруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн төсөл боловсруулах;

22.1.3.техникийн зохицуулалтыг баталж, мөрдүүлэх;

22.1.4.хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний жагсаалтыг батлах, хэрэгжилтийг хангуулах;

22.1.5.итгэмжлэлийн байгууллагын орон тооны дээд хязгаар, дүрмийг батлах.

**23 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

23.1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.салбарын хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах;

23.1.2.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

23.1.3.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх саналыг Засгийн газарт оруулж, шийдвэрлүүлэх;

23.1.4.чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, алдаршуулах зорилгоор үндэсний чанарын шагнал олгох;

23.1.5.энэ хуульд заасан төлбөртэй ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг чөлөөт зах зээлийн үнэ тарифтай уялдуулан тогтоох;

23.1.6.стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагын даргыг томилж, чөлөөлөх саналыг Засгийн газарт гаргах.

**24 дүгээр зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаар төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

24.1.Төрийн захиргааны төв байгууллага нь эрхэлсэн асуудлын хүрээнд стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1.салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хяналт шалгалт явуулах;

24.1.2.стандартыг шинэчлэн сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагатай хамтран зохион байгуулах;

24.1.3.эрхэлсэн асуудлаар энэ хуульд заасан Техникийн хороонд гишүүнийг ажиллуулах;

24.1.4.салбарын хэмжээнд дагаж мөрдөх стандартчилал, тохирлын үнэлгээний талаар нийтэд мэдээлэх, сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

24.2.Гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 13.4, 14.2-т заасан баримт бичгийг Монгол Улсын нэрийн өмнөөс Дэлхийн худалдааны байгууллагад мэдэгдэнэ.

## **25 дугаар зүйл.Стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллагын тогтолцоо**

25.1.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

25.2.Стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллагын тогтолцоо нь стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага, түүний харьяа аймаг, нийслэл дэх байгууллагаас бүрдэнэ.

25.3.Аймаг, нийслэл дэх стандартчилал, тохирлын үнэлгээний төрийн захиргааны байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээнд стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний бодлогын хэрэгжилтийг хангуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

25.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ энэ хуулийн биелэлтийг хангаж, стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

25.5.Салбарын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, хяналтын улсын байцаагч, албан тушаалтан нь хариуцсан чиглэлээр стандартчилал, тохирлын үнэлгээний хэрэгжилтийг хангуулж ажиллана.

## **26 дугаар зүйл.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага**

26.1.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

26.1.1.эрхэлсэн асуудлын хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэх;

26.1.2.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд баримтлах баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, хэм хэмжээ тогтоосон акт боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;

26.1.3.стандартчиллын техникийн хороо, дэд хороодыг байгуулах, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх;

26.1.4.техникийн хорооны дүгнэлтийг үндэслэн стандартыг батлах, хүчингүй болгох, бүртгэх, түүний албан ёсны эхийг хадгалах, олон нийтэд мэдээлэх, түгээх;

26.1.5.тохирлын үнэлгээг энэ хуульд заасны дагуу явуулах;

26.1.6.хариуцсан асуудлаар олон улсын байгууллагад гишүүнээр элсэх санал гаргах, олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх;

26.1.7.үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийг тодорхойлох, хяналт тавих;

26.1.8.хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах;

26.1.9.энэ хуульд заасан мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, удирдах, хяналт тавих;

26.1.10.энэ хуулийн 26.1.8-д заасан ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

26.1.11.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний онолын суурь судалгаа хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх;

26.1.12.чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг алдаршуулан үндэсний чанарын шагнал олгох үйл ажиллагааг зохион байгуулах.

## **27 дугаар зүйл.Аймаг, нийслэл дэх стандартчилал, тохирлын үнэлгээний төрийн захиргааны байгууллага**

27.1.Аймаг, нийслэл дэх стандартчилал, тохирлын үнэлгээний төрийн захиргааны байгууллага нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1.энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;

27.1.2.тохирлын үнэлгээг энэ хуульд заасны дагуу явуулах;

27.1.3.стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагын зөвшөөрснөөр гадаад улс, бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах;

27.1.4.үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийг тодорхойлох, хяналт тавих;

27.1.5.хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах;

27.1.6.энэ хуульд заасан мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх;

27.1.7.иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагад стандарт боловсруулах талаар арга зүйн зөвлөгөө өгөх, байгууллагын стандартыг бүртгэх;

27.1.8.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр төрийн хяналт шалгалтын байгууллага, эрх бүхий албан тушаалтантай хамтран ажиллах.

## **28 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний салбар дундын зохицуулалт**

28.1.Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, аймаг, нийслэлийн засаг дарга нь хариуцсан чиглэлээр стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулна.

28.2.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага нь салбар дундын уялдааг хангах зорилгоор төрийн захиргааны төв байгууллагатай хамтран дараах үйл ажиллагаа явуулна:

28.2.1.стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;

28.2.2.стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх;

28.2.3.стандартыг шинэчлэн сайжруулах зорилгоор таван жил хүртэлх хугацаанд шинжлэх ухаан, техникийн түвшинд үзлэг хийх;

28.2.4.стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн талаарх судалгаа, тайлан мэдээг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан эрх бүхий байгууллагаас жил бүр гаргуулах;

28.2.5.энэ хуульд заасан мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах.

28.3.энэ хуульд заасан тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхдээ тохирлын баталгаатай эсэхэд гаалийн байгууллага хяналт, шалгалт хийнэ.

28.4.Эрх бүхий этгээд тохирлын гэрчилгээг үндэслэн тодорхой төрлийн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулж болно.

28.5.Үндэсний стандарт, олон улсын болон бүс нутгийн стандарт боловсруулах зардлыг төсвийн байгууллага өөрийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

## **29 дүгээр зүйл.Төрийн хяналт**

29.1.Бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлснээс хойших үе шатанд стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн хяналтыг эрх бүхий улсын байцаагч хэрэгжүүлнэ.

29.2.Улсын байцаагч нь хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүн болон бусад хуулиар хэрэгжүүлэхээр заасан бүтээгдэхүүний тохирлын баталгаатай эсэхэд хяналт тавина.

29.3.Эрх бүхий хяналтын улсын байцаагч нь хяналт, шалгалтын үйл ажиллагаанд баталгаажуулалтын байгууллагын үр дүнг ашиглаж болно.

29.4.Энэ хуулийн 29.1-д заасан хяналтыг хэрэгжүүлэх улсын байцаагч нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

29.5.Энэ хуулийн 28.3-т заасан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

29.5.1.хууль тогтоомж, стандартчиллын баримт бичигт заасан шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх;

29.5.2.экспортлогч орны хүчин төгөлдөр тохирлын гэрчилгээ, нийлүүлэгчийн мэдэгдэл, түүнтэй адилтгах гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх;

29.5.3.тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх;

29.5.4.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 14.2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр тэмдэг, гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, Улсын хилээр нэвтрүүлэхэд тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй байх;

29.5.5.тохирлын баталгаатайгаар улсын хилээр нэвтрүүлсэн бараа, бүтээгдэхүүний статистик мэдээллийг стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагад хагас жил тутам ирүүлэх.

29.6.Сорьцын хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

29.6.1.үнэт металл, түүгээр хийсэн эдлэлийн сорьц тогтоох, эрдэнийн чулууг тодорхойлохтой холбоотой хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

29.6.2.үнэт металл, түүгээр хийсэн эдлэлд сорьц тогтоосон болон эрдэнийн чулууг тодорхойлсон эсэхэд хяналт тавих;

29.6.3.шаардлагатай тохиолдолд лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

29.6.4.үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийг тодорхойлсон талаар дүгнэлт гаргах;

29.6.5.үнэт металлын сорьцын баталгааны тэмдэг болон үйлдвэрлэгчийн барааны тэмдэглэгээнд хяналт тавих;

29.6.6.эрх бүхий хуулийн этгээдийн сорьц тогтоох үйл ажиллагаанд хяналт тавих.

### **30 дугаар зүйл.Иргэн, хуулийн этгээдийн эрх үүрэг**

30.1.Иргэн, хуулийн этгээд нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар дараах эрхтэй:

30.1.1.бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлээр стандарт, менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, тохирлын үнэлгээнд хамрагдах;

30.1.2.стандарт санаачлах, боловсруулах;

30.1.3.стандарт, стандартчиллын хөтөлбөрийн төсөлд санал өгөх.

30.2.Иргэн, хуулийн этгээд нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар дараах үүрэгтэй:

30.2.1.стандарт, техникийн зохицуулалтаар тогтоосон шаардлагын дагуу бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;

30.2.2.стандартыг боловсруулах, бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах, түүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх;

30.2.3.стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр ажилтныг чадавхжуулах;

30.2.4. хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын баталгаатайгаар Монгол Улсын зах зээлд нийлүүлэх;

30.2.5.тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх;

30.2.6.хуульд заасан бусад.

30.3.Иргэн, хуулийн этгээд, сонирхогч талуудын боловсруулсан стандартын төсөл нь хууль тогтоомж, техникийн зохицуулалт болон үйлдвэрлэгч, хэрэглэгчийн эрх ашигт харшлаагүй, нийтийн ашиг сонирхол, хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахааргүй байна.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН САН**

### **31 дүгээр зүйл.Мэдээллийн сан**

31.1.Стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид “Мэдээллийн сан” гэх) –тай байна.

31.2.Мэдээллийн сан дараах төрөлжсөн сангаас бүрдэнэ:

31.2.1.стандартчиллын баримт бичгийн мэдээллийн сан;

31.2.2.итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын мэдээллийн сан;

31.2.3.баталгаажуулалтын үр дүнгийн мэдээллийн сан;

31.2.4.лабораторийн шинжилгээний үр дүнгийн мэдээллийн сан;

31.2.5.техникийн хяналтын үр дүнгийн мэдээллийн сан;

31.2.6.сорьц тогтоолгон баталгаажсан үнэт металлаар хийсэн бүтээгдэхүүний болон гэрчилгээтэй эрдэнийн чулууны мэдээллийн сан;

31.2.7.баталгаажуулалтын шинжээчийн мэдээллийн сан;

31.2.8.стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн хяналтын мэдээллийн сан;

31.2.9.энэ хуулийн хүрээнд хамаарах бусад.

31.3.Мэдээллийн сан нь нэгдсэн удирдлага зохицуулалт бүхий программ хангамжтай байна.

31.4.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага мэдээллийн санг удирдах, хөгжүүлэх, нууцлал, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангана.

### **32 дугаар зүйл.Мэдээллийн сан бүрдүүлэх, хөгжүүлэх**

32.1.Энэ хуулийн 31.2-т заасан төрөлжсөн мэдээллийн санг дараах байгууллагууд бүрдүүлнэ:

32.1.1.стандартчилал, тохирлын үнэлгээний төрийн захиргааны байгууллага;

32.1.2.итгэмжлэлийн байгууллага;

32.1.3.төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага;

32.1.4.гаалийн байгууллага;

32.1.5.тохирлын үнэлгээний байгууллага;

32.1.6.бусад.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан байгууллагууд мэдээллийн сангийн мэдээллийг тухай бүр оруулна.

32.3.Мэдээллийн сан нь эрх бүхий байгууллагууд мэдээлэл оруулах, солилцох, хянах нөхцөлийг бүрдүүлж ашиглах боломжтой байна.

32.4.Мэдээллийн санд мэдээлэл бүртгэх, баяжуулах, баталгаажуулах чиг үүргийг энэ хуулийн 32.1-д заасан байгууллага мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

### **33 дугаар зүйл.Мэдээллийн санг ашиглах, хадгалах, хамгаалах**

33.1.Мэдээллийн сангийн өгөгдөл нь нээлттэй, хаалттай гэсэн төрөлтэй байх бөгөөд мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллээс төрийн болон албаны, хувь хүн, хуулийн этгээдийн нууцад хамаарах болон олон улсын гэрээ хэлэлцээрт нууцлахаар зааснаас бусад мэдээлэл нь нийтэд нээлттэй байна.

33.2.Мэдээллийн сан бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах хүрээнд стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага шаардлагатай программ хангамж, техник хэрэгслээр хангагдсан байна.

33.3.Мэдээллийн сан үрэгдэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд мэдээллийн санг нөөцлөн цахим технологийн дагуу Архивын тухай хууль тогтоомжид заасан хугацаанд хадгална.

33.4.Мэдээллийн сангийн мэдээлэл бодит бус байгаа нь баримтаар тогтоогдвол энэ хуулийн 32.1-д заасан байгууллага залруулгыг хийнэ.

33.5.Мэдээллийн сан хариуцсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан мэдээллийн санг бусад этгээдэд шилжүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгоор ашиглахыг хориглоно.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ**

### **34 дүгээр зүйл.Санхүүжилт**

34.1.Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага, түүний харьяа аймаг, нийслэлийн байгууллага болон итгэмжлэлийн байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

34.2.Энэ хуульд заасан стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар онолын суурь судалгаа хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зардлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлнэ.

34.3.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос стандартчилал, техникийн зохицуулалтын техникийн шинэчлэл, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зардлыг санхүүжүүлж болно.

34.4.Стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн санхүүжилт нь энэ зүйлийн 34.1, 34.2-т зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

34.4.1.төлбөртэй ажил, үйлчилгээний хураамж;

34.4.2.олон улсын байгууллага, хандивлагч орны хандив, тусламж;

34.5.Энэ хуульд заасан төлбөртэй ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг чөлөөт зах зээлийн үнэ тарифтай уялдуулан стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА**

**35 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

35.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчил, гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

35.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**36 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

36.1.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ....-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Автотээврийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “хуулийн 9.1-д заасны дагуу стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “хуульд заасны дагуу стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “стандартчиллын байгууллага тогтооно.” гэснийг “стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага батална.” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЯЖУУЛСАН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Баяжуулсан хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсгийн “стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол хэлний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.6 дахь заалтын “хуулийн 9.1-д” гэснийг “хуульд” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ  
ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа үндэсний стандартын баримт бичгийн үзлэгийг 2026 оны эхний хагас жилд багтаан үе шаттайгаар зохион байгуулж, шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, батална.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Стандартчиллын Үндэсний зөвлөл батална.” гэснийг “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу батална.” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН  
АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “хуулийн 9.1-д” гэснийг “хуульд” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн "Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын" гэснийг "Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагын" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**“СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН”  
ХЭЛЭЛЦҮҮГИЙН ТАНИЛЦУУЛГА  
(2025.02.19-21)**

“Стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин” хэлэлцүүлгийг Улаанбаатар хот, Төрийн ордонд 2025 оны 02 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийг:

1. “Барилгын салбарын стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин”;
  2. “Эрүүл мэндийн салбарын стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин” хэлэлцүүлэг;
  3. “Хүнсний салбарын стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин” хэлэлцүүлэг;
  4. “Хүрээлэн бус орчны стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин” хэлэлцүүлэг;
- гэсэн сэдвээр тус тус зохион байгуулж 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр “Стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин” нэгдсэн хуралдаанаар зохион байгуулж, нэгтгэн хуралдсан.

Хэлэлцүүлэгт Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаар ахлуулсан “Стандартын эрх зүйн орчныг шинэчлэх, санал дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”, Шадар сайдын Ажлын алба, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн яам, Стандарт, хэмжил зүйн газар, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газар, Үндэсний итгэмжлэлийн төв, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ, ШУТИС, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн чанар аюулгүй байдлын мэргэжлийн салбар зөвлөл, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Монголын хүнсчдийн нэгдсэн холбоо, Гаалийн ерөнхий газар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр болон холбогдох аж ахуйн нэгж байгууллага, ТББ, иргэдийн төлөөллийг хамрууллаа. Хэлэлцүүлэгт нийт 1000 гаруй оролцогч хамрагдаж, давхардсан тоогоор барилгын салбараас 33, эрүүл мэндийн салбараас 32, хүнс, хөдөө аж ахуйн салбараас 15, хүрээлэн буй орчны хэлэлцүүлгээс 18 санал, зөвлөмж тус тус гарсан байна.



“СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН”  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (2025.02.19-21)



**СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН САНАЛЫН ТОВЬЕГ**  
(2025.02.19-21)

**БАРИЛГЫН САЛБАРЫН СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

| Д/д | Гаргасан санал  | Тайлбар  |
|-----|---|--|
| 1   | Барилгын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөлд тусгасан Барилгын салбарын судалгаа, шинжилгээний байгууллага байгуулахыг дэмжих                              | Энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй ба тухайн салбарын хуулиар зохицуулах |
| 2   | “Барилга байгууламжийн норм нормативын сангийн журам”-ыг шинэчлэх, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн ТББ-ын төлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх |  |
| 3   | Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулах хүрээнд төсөвт өртгийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийж , холбогдох журамд өөрчлөлт оруулах       |  |
| 4   | Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг хэрэглэх эрх зүйн орчныг сайжруулах                             | Хуулийн төслийн 24.1.2-т тусгагдсан.                                   |

**Барилгын норм, дүрэм, стандартыг сайжруулах чиглэлээр:**

| Д/д | Гаргасан санал  | Тайлбар  |
|-----|---|--|
| 1   | Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах, тэдгээрт үзлэг хийж давхардлыг арилгах үйл ажиллагаанд дэвшилтэд технологи нэвтрүүлэх | Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т тусгагдсан.<br>Мөн дагах хуулийн төсөлд тусгасан.   |
| 2   | Салбар хоорондын уялдаа холбоог хангах үүднээс барилга байгууламжийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх   | Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.1-т тусгагдсан.   |
| 3   | Барилга байгууламжийн норм нормативын сангийн төлөвлөгөөнд туслуулахаар ирүүлсэн ажлуудыг ач холбогдлоор эрэмбэлж тусгаж, батлах                        | -  |
| 4   | Барилга байгууламжийн норм, нормативын сангийн орлого төвлөрүүлэлт, зарцуулалтыг олон нийтэд нээлттэй ил тод байлгах                                    | -  |
| 5   | Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт, Лифтний техникийн зохицуулалт зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, батлуулах   | Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 28 дугаар зүйлийн 28.2.4-т тус тус тусгасан.   |
| 6   | Барилгын стандартуудыг үнэгүй болгох асуудлыг судалж, шийдвэрлэх  | Үндэсний стандартыг цахим орчинд үнэ төлбөргүй харах, хэрэглэх боломжийг бүрдүүлсэн.<br>Олон улсын байгууллагын гишүүн байгууллагын үүргийн хүрээнд саналыг хүлээн авах боломжгүй. |

## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### Нийтлэг

| Д/д | Гаргасан санал   | Тайлбар   |
|-----|--|---|
| 1   | Стандартын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход бие дааж санхүүжүүлэх санхүүгийн механизм бүрдүүлэх. (Жишээлбэл: БХТ)   | Салбарын хууль түс бүрээр зохицуулах боломжтой. |
| 2   | Стандарт боловсруулах, хэрэгжүүлэх, хянах тогтолцоонд төрийн оролцоог багасгаж, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн санаачилгыг нэмэгдүүлэх  | -   |
| 3   | Стандарт шинээр боловсруулах, батлах, хүчингүй болгох процессыг шуурхай болгох үүднээс хугацааг богиносгох, төрийн оролцоог багасгах   | -   |
| 4   | Шинэчлэх шаардлагатай эрүүл мэндийн стандартуудыг шинэчлэх, хэрэгжиж байгаа стандартад тогтмол хугацаанд үнэлгээ, үзлэг хийдэг байх, үзлэгийн үр дүнд үндэслэн арга хэмжээ авч байх, хариуцлагын тогтолцоог сайжруулах | -   |
| 5   | Стандарт, магадлан итгэмжлэлийн талаарх ач холбогдол, хэрэгцээ шаардлагын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх;   | -   |

### Нийгмийн эрүүл мэнд, эмнэл зүйн чиглэлээр

| Д/д | Гаргасан санал   | Тайлбар  |
|-----|--|--|
| 1   | Олон улсын жишгээр хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хяналтыг цогцоор шийдэх  | Хуулийн төслийн 28, 29 дүгээр зүйлд салбар дундын зохицуулалтаар зохицуулсан.  |
| 2   | Бүх салбарт эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах шаардлага үзүүлэлтийг тусгах зохицуулалтыг оруулж, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг байх | Хуулийн төслийн 5, 13 дугаар зүйлд тус тус тусгасан ба техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээнд заавал хамруулахаар тусгасан. |
| 3   | Олон улсын заавар удирдамжид орсон эм, эмчилгээ, оношилгоог хэрэглэх эрхзүйн орчныг бүрдүүлэх  | Хуулийн төсөлд хамаарахгүй харилцаа  |
| 4   | Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, түгээмэл тусламж, үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний стандарт зааврыг бий болгох.                               | Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.5-т тусгасан. (шинээр)  |

### Эм зүйн чиглэлээр

| Д/д | Гаргасан санал   | Тайлбар   |
|-----|--|---|
| 1   | Эмзүйн салбарт мөрдөж буй зохицуулалтын 5 стандартыг эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нийцүүлэн төслийг шинэчлэн боловсруулах | Хэрэгцээ шаардлагатай стандартыг боловсруулах нь иргэн, хуулийн этгээдэд нээлттэй. Хуулийн төсөлд тусгагдсан. |

|   |   |  |
|---|---|--|
| 2 | Салбарын стандартуудад үзлэг, үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээ авах   | Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т тусгагдсан.<br>Мөн дагах хуулийн төсөлд тусгасан. |
| 3 | Эмнэлгийн хэрэгслийн чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 13485:2021 стандартыг эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрүүдэд дагаж мөрдөх эрхзүйн орчныг бүрдүүлэх                                 | Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1-т тусгасан.   |
| 4 | Дотоодын үйлдвэрийн анхдагч эм, ургамлын гаралтай эм, уламжлалт эм, тэдгээрийн түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг шинжлэх үндэсний фармакопейг шинэчлэн боловсруулах ажлыг эрчимжүүлэх | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 5 | Монгол улсын үндэсний фармакопейг 3-5 жил тутам шинэчлэн сайжруулахад шаардлагатай төсвийг шийдвэрлэх   | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 6 | Дотоодын болон гадаадын ерөнхий нэршлийн эм, тэдгээрийн түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг шинжлэхэд үндэсний болон олон улсад зөвшөөрөгдсөн фармакопейг ашиглах.                      | Хуулийн төсөлд хамааралгүй.  |

#### Лабораторийн чиглэлээр

| Д/д | Гаргасан санал  | Тайлбар   |
|-----|---|---|
| 1   | Бүх лабораториудыг магадлан итгэмжилдэг байх. (MNS ISO 15189: 2024, MNS ISO/IEC 17043:2003 энэ хоёр стандартаар итгэмжлэгдэж байж, дэлхий улс орнуудын эрүүл мэндийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдөнө) | Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зохицуулалтыг хуулийн төслийн 19, 20 дугаар зүйлээр зохицуулсан. |
| 2   | Эрүүл мэндийн лабораториудыг итгэмжлэлийг “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах                                    |   |
| 3   | Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох аж ахуйн нэгжүүд эм, эмнэлгийн хэрэгслийн сорилт, туршилтын лабораторитой болох, бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулдаг болох                                   |   |
| 4   | Эм, эмнэлгийн хэрэгслийн баталгаажуулалтын байгууллага нь олон улсын стандарт шаардлагад нийцсэн байх   |   |
| 5   | Өнөөгийн хяналтын тогтолцоог сайжруулж, нэгдсэн зохицуулалттай болгоход эмийн агентлагийн чиг үүргийг нэмэгдүүлж Хүнс, эмийн агентлаг болгон өргөжүүлэх.  | Хуулийн төсөлд хамааралгүй болно.   |

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### Хууль эрх зүйн чиглэлээр

| Д/д | Гаргасан санал  | Тайлбар   |
|-----|---|---|
| 1   | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах заалтыг “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгах   | Хуулийн төслийн 5, 13, 30.2.4-т тус тус тусгасан ба техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээнд заавал хамруулахаар тусгасан. |
| 2   | Хүнсний салбарын 650 стандартын 150 гаруй стандартыг шинэчилж нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай стандартыг шинээр боловсруулж батлах   | Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т тусгагдсан.<br>Мөн дагах хуулийн төсөлд тусгасан.                                |
| 3   | Стандартыг боловсронгуй болгох чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хөгжиж буй орнуудын түншүүдтэй хамтарч ажиллах  | Хуулийн төслийн 28 дугаар зүйлд салбар дундын зохицуулалтаар тусгасан.  |
| 4   | “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага”, “Ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон ус, ундаа, шүүсний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг шинээр боловсруулж батлуулах | -   |

### Стандарт, техникийн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр

| Д/д | Гаргасан санал   | Тайлбар  |
|-----|--|--|
| 1   | Стандарт худалдан авах процессыг ил тод, нээлттэй болгох   | Мэдээллийн сангийн талаархи 6 дугаар бүлэгт заасан зохицуулалтад тусгасан. |
| 2   | Техникийн зохицуулалтад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт, бохирдлын зөвшөөрөгдөх хэмжээ, сахар, транс тосны агууламжийн зөвлөмж хэмжээг нарийвчилж тодорхой тусгах  | -  |
| 3   | Хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоолны тоног төхөөрөмж, сав хэрэгслийн хийц, чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлагын стандартад ган төмөр /нерж/, хөнгөн цагаан, никель савны марк, төрөл болон хуванцрын төрлийг тодорхой тусгах | -  |
| 4   | Стандарт, техникийн зохицуулалтад тусгагдаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлагыг боловсруулж батлах  | -  |
| 5   | Хүнсний салбарын стандарт мөрдөлтийг үе шат бүрд нь цахимаар хянах тогтолцоог бүрдүүлэх.   | -  |

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ СТАНДАРТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН

| Д/д | Гаргасан санал   | Тайлбар  |
|-----|--|--|
| 1   | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, лабораториудад ашиглагддаг урвалж, бодисуудын хэрэглээ, нийлүүлэлтийг хялбаршуулах, технологийн дэвшил ашиглах   | -  |
| 2   | Байгаль орчны салбарын стандартуудыг олон улсын стандартад нийцүүлэх, зохицлыг сайжруулах, шинэчлэх, хүчингүй болгох зорилгоор стандартын техникийн үзлэгийг хийх  | Дагах хууль  |
| 3   | Хүрээлэн буй орчны хяналт, шинжилгээний техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийх, лабораториудын хүний нөөц, хүчин чадлыг нэмэгдүүлэх санхүүжилтийг шийдвэрлэх. Тухайлбал: Агаарын чанарын стандартад нийт 611 үзүүлэлт тусгагдсанаас түгээмэл тархалттай 6 үзүүлэлтийг шинжлэх чадамжтай байгааг анхаарах  | -  |
| 4   | Стандартын хэрэгжилтэд иргэдийн хяналтыг нэвтрүүлэх, төрийн бус байгууллагад хяналтыг шилжүүлэх, урамшуулах, хүрээлэн буй орчны стандартуудыг иргэдэд хялбар ойлгомжтой байдлаар хүргэх  | Хуулийн төслийн 30 дугаар зүйлд тусгасан.<br>(иргэн, хуулийн этгээдийн эрх үүрэг)                                    |
| 5   | Судалгааны байгууллага, хүрээлэн, лабораториудад хийгдэж буй байгаль орчны хяналт шинжилгээний хэмжилт, тайлан мэдээллийг иргэд, байгаль орчны үнэлгээний аж ахуйн нэгжүүд ашиглах боломжийг бүрдүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах  | Хуулийн төслийн 6 дугаар бүлэгт тусгаж зохицуулсан.  |
| 6   | Хүн амын ундны усны чанарын стандартын асуудлыг онцгой анхаарах, шугам сүлжээний шинэчлэлийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хэлбэрээр хийх  | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 7   | Стандартгүй боловч зохицуулах шаардлагатай асуудлыг хэрхэн шийдэх талаар тодорхой бодлого, чиглэл гаргах, стандарт зохицуулалтгүй байгаа Хог хаягдал шатаах зуухнаас гарах бохирдлын стандартыг яаралтай бий болгох  | Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т тусгагдсан.<br>Мөн дагах хуулийн төсөлд тусгасан.                         |
| 8   | Саарал устай холбоотой эрхгүйн зохицуулалтыг тодорхой болгох   | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 9   | Судалгааны үр дүн, тайланг нээлттэй, олон нийтэд ил болгох   | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 10  | Байгаль орчны төлөв байдлын тайланг УИХ дээр эргэн хэлэлцдэг болох   | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 11  | Лабораторийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх  | Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолоор зохицуулсан.   |
| 12  | Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээг нэгдсэн байдлаар хийлгэх, байгаль орчны салбарын 4 техникийн зохицуулалтын хэрэгжилтийг улсын хэмжээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газраас хийж, дээрх хуулийн 5-р зүйлийн 5.3 дахь заалтыг хэрэгжүүлэх. | Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.2.2, 28.2.3 дахь заалтаар зохицуулагдсан.<br>Мөн дагах хуулийн төсөлд тусгасан. |

## НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧДЫН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

### ХҮНС, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ САЛБАР

| Д/д | Гаргасан санал  | Тайлбар   |
|-----|---|---|
| 1   | Бүтээгдэхүүний хадгалалтын хугацааны асуудал, гаалийн хяналтыг сайжруулах (хугацааг өөрчлөн худалдаанд гаргаж байгаа асуудлын хяналт байхгүй байгааг анхаарах, хяналтын тогтолцоог нарийвчлах, ил болгох) | Хуулийн төслийн 28, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгээр зохицуулсан.                       |
| 2   | Худалдааны байгууллагын Эрсдэлийн үнэлгээний журам батлуулах  | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 3   | Чөлөөт бүс-гаалийн татвараас зайлсхийх асуудлыг зохицуулах  | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 4   | Гаалийн бүрдүүлэлт хийх, хугацаа, шат дамжлагыг багасгах, хөнгөвчлөх  | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 5   | Зөвшөөрлийг цахимаар түргэн шуурхай олгодог болгох, зөвшөөрөл эзэмшигч стандарт, хууль, журам зөрчөл зөвшөөрлийг хүчингүй болгодог, дахин олгодоггүй байх хатуу зохицуулалт бий болгох                    | Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.4-т тусгасан.  |
| 6   | Хүнсний аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалт, хариуцлагыг дээшлүүлэх.   | Хуулийн төслийн 29 дүгээр зүйлд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан. |

### ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

| Д/д | Гаргасан санал   | Тайлбар   |
|-----|--|---|
| 1   | Дотоод орчны агаарын бохирдлын стандартыг боловсруулж батлах   | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 2   | Эмчилгээ, оношилгооны стандартыг Зөвлөмжийн чанартай болгох  | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 3   | Эрүүл мэндийн салбарт давхцаж буй стандартыг арилгах   | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 4   | Эрүүл мэндийн байгууллагын итгэмжлэлийг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх   | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 5   | Итгэмжлэлийн ач холбогдлын олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх  | -   |
| 6   | Техникийн хорооны хэлэлцүүлгийн шатанд шинжээчийн баг оролцуулах   | Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд техникийн хорооны эрх үүргийг тусгасан. |
| 7   | Нэр томъёоны тодорхойлолт хуульд байдаггүй тул нийцүүлэх   | Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд нарийвчлан зохицуулсан.                  |
| 8   | Хүний нөөцийн тоог стандартчилсан нь бодит байдалд нийцэхгүй байгаа  | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 9   | Хөдөлмөрийн тухай хууль болон салбарын хуулийн нийцлийн асуудал  | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 10  | Хувиараа бизнес эрхэлж эмийн сан ажиллуулахад хүндрэлтэй болсон. Стандартын зөрчил гаргахад Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага өндөр болсон | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 11  | Оршууллын газрын орчны бохирдол, ариутгалын асуудлыг зохицуулах, тохирлын баталгаанд заавал хамруулах жагсаалтад оруулах                               | Хуулийн төслийн 13.4-т тусгасан.  |

|    |   |                               |
|----|---|-------------------------------|
| 12 | Утаа, гадаад орчны бохирдлыг шалгах лабораторийн ажиллах нөхцөлийг бий болгох, хүчин чадлыг нэмэгдүүлэх       | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 13 | Стандартын хяналтыг сайжруулах  | Хуулийн төслийн 28, 29 дүгээр |
| 14 | Стандартын төлбөр, орчуулга хүндрэлтэй байдаг тул олон улсын стандартын жагсаалтыг яамд ил тод гаргадаг болох | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 15 | Лабораторийн тухай хууль боловсруулахад олон нийт, салбарын төлөөлөөс судалгааг онцгойлон авах                | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 16 | Туул голын усны бохирдлын асуудлыг холбогдох байгууллагууд онцгой анхаарах                                    | Хуулийн төсөлд хамааралгүй.   |
| 17 | Нийтийн ариун цэврийн асуудлыг стандартчилах.   | Хуулийн төсөлд хамааралгүй.   |

### БАРИЛГЫН САЛБАР

| Д/д | Гаргасан санал   | Тайлбар  |
|-----|--|--|
| 1   | Барилга хоорондын зай, орон сууцны талбайг хэмжих стандартын хэрэгжилтийг хангуулах, салбар хоорондын уялдааг сайжруулах   | Салбарын хууль тогтоомжийн шинэчлэлээр зохицуулах боломжтой.                             |
| 2   | Барилгын салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт бичгийг боловсруулж мөрдүүлэх   |  |
| 3   | Олон гарын үсэг цуглуулдаг, хугацаа их ордог асуудлыг багасгах   |  |
| 4   | Хот төлөвлөлтийн асуудлыг бодлогоор цогцоор шийдвэрлэх, барилгын олон норм дүрмийг цэгцлэх, хяналтын улсын байцаагчдын тоог нэмэгдүүлэх, барилга баригдсан хойно нь хяналт тавих бус баригдаж байхад нь хяналт тавих | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 5   | Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, гэрээний хяналт, тайлагнах асуудлын уялдааг хууль журамд нийцүүлэх  |  |
| 6   | Хилээр орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах   | Хуулийн төслийн 28, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгээр зохицуулсан.                      |
| 7   | Олон улсын жишиг буюу барилга баригч үнэлгээ, тооцроогоо өөрөө хийж, хариуцлагаа мөн өөрөө хүлээх зохицуулалтыг тусгах   | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 8   | Барилга байгууламжийн салбарын дүрэм журам, норм дүрмийн тоог цөөрүүлэх  | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 9   | Тусгай зөвшөөрөлд чанар хамгуулах инженерүүдийг заавал тусгах  | Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудлыг хуулийн төслийн 20 дугаар зүйлээр зохицуулсан. |
| 10  | Хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториудыг оролцуулах  |  |
| 11  | Тохирлын гэрчилгээнд Чанар, стандартуудыг шаардлагуудыг тусгах   | Хуулийн төслийн 11.2.3-т тусгаж зохицуулсан.   |
| 12  | ББНД-ийг заримыг сонгон хэрэглэхээр тусгах   | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 13  | Барилгын норм, дүрэм, стандарт боловсруулах, батлах үе шат, дамжлагыг олон улсын жишигт нийцүүлж багасгах  | Хуулийн төсөлд хамааралгүй.  |
| 14  | Барилгын мэргэжилтэн ажилтны ажиллах хүчний дутагдлын асуудлыг шийдвэрлэх  | Хуулийн төсөлд хамааралгүй.  |

|    |   |                             |
|----|---|-----------------------------|
| 15 | Улсын чанартай барилгуудын чанар, стандартад нэгдсэн хяналт тавьж, анхааралдаа авах       | Хуулийн төсөлд хамааралгүй. |
| 16 | Худалдан авах ажиллагаанд тухайн салбарын мэргэжлийн ТББ-ыг оролцуулах                    | Хуулийн төсөлд хамааралгүй. |
| 17 | Ундны усны чанарын асуудал анхаарал хандуулж, ундны усны гол хоолойг зэс коллатороор хийх | Хуулийн төсөлд хамааралгүй. |
| 18 | Аж үйлдвэрийн оношилгооны ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, ажиллуулах.        | Хуулийн төсөлд хамааралгүй. |

---o0o---

**СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ  
ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН  
ҮНЭЛГЭЭ /2022 он/**

**АГУУЛГА**

**Товчилсон үгсийн жагсаалт**

**Удиртгал**

**НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ**

1. 1 Үнэлгээ хийх шалтгаан
1. 2 Үнэлгээ хийх хүрээ
1. 3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт
1. 4 Үнэлгээний харьцуулах хэлбэр
1. 5 Шалгуур үзүүлэлтийг томьёолох
1. 6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

**ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

**ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ**

3. 1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал
- 3.2. “Хүлээн зөвшөөрөгдсөн” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал
- 3.3. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

**ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

5. 1 Дүгнэлт
5. 2 Зөвлөмж

**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

**ХАВСРАЛТ**

## УДИРТГАЛ

Стандарт, хэмжил зүйн газрын захиалгаар “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой. Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

## НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- Харьцуулах хэлбэрийг сонгох
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

### 1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн /цаашид “СТЗТҮИтХ” гэх/ шинэчилсэн найруулга 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр батлагдаж 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд дагаж мөрдөгдөөд хэдийн 4 жилийн хугацаа өнгөрсөн байна. Энэхүү хуулийн шинэчилсэн найруулгаар стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлж, зохицуулаагүй харилцааг зохицуулснаараа дэвшилттэй хууль болсон билээ.

Монгол Улсад 2022 оны 10 дугаар сарын байдлаар 6525 стандарт хүчин төгөлдөр байна. Стандарт нь холбогдох хууль тогтоомжоор заавал дагаж мөрдөхөөр заагаагүй бол сайн дураар буюу үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь сонгон хэрэглэх баримт бичиг байдаг нь олон улсын практик юм. Иймд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заавал дагаж мөрдөх шаардлагатай стандартуудыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн орчин хэрэгтэй байна.

Түүнчлэн хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох боломж нээлттэй боловч хувийн хэвшлийн оролцоог нарийвчлан тодорхойлоогүйгээс гадна төрийн зүгээс тохирлын үнэлгээ хийсээр байгаа нь хувийн хэвшлийн байгууллагууд хангалттай хэмжээнд хүрч хөгжихөд хязгаарлалт болж байна. Цаашилбал итгэмжлэлийн үйл ажиллагааны үр дүнд тохирлын үнэлгээний байгууллага ажиллагаа явуулах боловч тухай салбарт тохирлын үнэлгээний ажлыг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагыг Засгийн газрын гишүүн томилж байгаа нь хувийн хэвшлийн байгууллагад шат дамжлага нэмэгдүүлсэн, зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан байна.

## **1.2. Үнэлгээ хийх хүрээ**

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан байна. Иймд СТЗТҮИтХ-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий заалтуудаар үнэлгээний хүрээг тогтоох шаардлагатай.

Иймд дээрх шалгуур үзүүлэлтийг үндэслэн СТЗТҮИтХ-ийн 1 дүгээр зүйлд зааснаар “Энэ хуулийн зорилт нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан тул хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хэд хэдэн зохицуулалтуудыг үнэлэх шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал,

- **Техникийн зохицуулалт**

СТЗТҮИтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэг  
СТЗТҮИтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсэг  
СТЗТҮИтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь хэсэг  
СТЗТҮИтХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг

- **Стандартыг сонгон хэрэглэх**

СТЗТҮИтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг  
СТЗТҮИтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг  
СТЗТҮИтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг  
СТЗТҮИтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг

- **Хяналт шалгалт**

СТЗТҮИтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт

## **1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт**

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтүүдээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

- зорилгод хүрсэн түвшин
- хүлээн зөвшөөрөгдсөн байдал
- практикт нийцэж байгаа байдал

**1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр** Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрүүдээс 3.5.3.1. “байх ёстой болон одоо байгаа байдал”, мөн 3.5.3.4. “тохиолдол судлах” хэлбэрүүдийг сонголоо.

Учир нь, одоо байгаа нөхцөл байдлыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлагатай харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн

зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохын тулд “байх ёстой болон одоо байгаа” харьцуулах хэлбэрийг хэрэглэхээр заасан.

Бид үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтуудын хувьд зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтүүдээр шалгахад тогтоосон тул үүнтэй уялдуулан дээрх харьцуулах хэлбэрийг сонгов.

Мөн үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтууд бусад улс орнуудын хувьд хэрхэн хэрэгждэг талаар судлах үүднээс “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг сонгосон болно. Бусад улс орнуудын СТЗТҮИтХ тогтоомжийг харьцуулан судлах нь тус хуулийг сайжруулахад зайлшгүй хийгдэх ёстой судалгаа гэж үзлээ.

#### **1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох**

Дээр тайлбарласан ёсоор бид энэхүү үнэлгээг хийхэд зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал болон хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авсан бөгөөд дараах асуултуудыг боловсрууллаа.

##### ***Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:***

- СТЗТҮИтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт зорилгодоо хүрсэн эсэх?
- СТЗТҮИтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт зорилгодоо хүрсэн эсэх?
- СТЗТҮИтХ-ийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг зорилгодоо хүрсэн эсэх?

##### ***Хүлээн хүлээн зөвшөөрөгдсөн байдал:***

- СТЗТҮИтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дах хэсэг хүлээн зөвшөөрөгдсөн эсэх?
- СТЗТҮИтХ-ийн 14 дүгээр зүйлийн дугаар зүйлийн 14.1 дэх хэсэг хүлээн зөвшөөрөгдсөн эсэх?

##### ***Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:***

- СТЗТҮИтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- СТЗТҮИтХ-ийн 13 дугаар зүйл практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- СТЗТҮИтХ-ийн 25 дугаар зүйл практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- СТЗТҮИтХ-ийн 26 дугаар зүйл практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- СТЗТҮИтХ-ийн 29 дүгээр зүйл практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

#### **1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох**

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны ажил уншиж, судлах, харьцуулалт хийх, мэргэжилтнүүдтэй уулзаж, ярилцах, санал солилцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

- Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу бэлэн байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд:
  - СТЗТҮИтХ-д холбогдох хууль тогтоомж
  - Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц
  - бусад эрх зүйн баримт бичиг
  - ном
  - нэг сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл
  - судалгааны тайлан
  - статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.
- Аргачлалын 3.7.3.2-т заасны дагуу холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд СТЗТҮИтХ-ийн үйлчлэлд хамаарах худалдаа, үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж

байгууллага болон хуульч, судлаачдаас фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авсан болно.

### **ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

СТЗТҮИтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ бэлэн байгаа мэдээллийг цуглуулах, холбогдох субъектээс судалгаа авах аргаар холбогдох материалыг цуглуулан үнэлгээг хийсэн болно.

- Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах

#### ***Хууль, эрх зүйн акт***

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Захиргааны хууль, 2013
3. Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2018
4. Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050
5. Улсын их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого
6. Улсын их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
7. Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоол
8. Засгийн газрын 2019 оны 235 дугаар тогтоол
9. Евро парламентын 2008 оны 765 дугаар чиглэл
10. Япон улсын Аж үйлдвэрийн стандартын тухай хууль
11. Евро парламентын 2012 оны 1025 дугаар чиглэл

#### ***Цахим эх сурвалж***

1. <http://opendata.burtgel.gov.mn/lesinfo/8172676>
2. <https://forum.parliament.mn/projects/187>
3. <https://www.mnas.gov.mn/Use%20of%20Logos%20and%20Marks>
4. <https://emi.qcc.gov.ae/-/media/Project/QCC/EMI/Documents/TheNationalQualityInfrastructure.pdf>
5. <http://nml.gov.ph/wp-content/uploads/2013/02/THE-ANSWER-TO-THE-GLOBAL-QUALITY-CHALLENGE- A-NATIONAL-QUALITY-INFRASTRUCTURE.pdf>
6. [https://www.wto.org/english/res\\_e/booksp\\_e/tbt3rd\\_e.pdf](https://www.wto.org/english/res_e/booksp_e/tbt3rd_e.pdf)
7. [https://www.unido.org/sites/default/files/2017-02/GUIDE\\_FOR\\_THE\\_DEVELOPMENT\\_OF\\_0.pdf](https://www.unido.org/sites/default/files/2017-02/GUIDE_FOR_THE_DEVELOPMENT_OF_0.pdf)
8. <https://pubdocs.worldbank.org/en/249621553265195570/69dba889394378338787139226.pdf>
9. <https://openknowledge.worldbank.org/handle/10986/2305>

#### ***Статистик мэдээ, судалгааны тайлан, ном***

1. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэл
2. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хурлын тэмдэглэл

3. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэл
4. Стандарт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс 2022 оны 10 дугаар сарын 05-ны Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж гарсан. Тухайн захирамжийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газар хуулийн холбогдох оролцогч нарыг хамруулан хуулийн хэрэгжилтэд авсан саналын тэмдэглэл.

## ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу СТЗТҮИтХ-аас сонгож авсан зохицуулалтуудад дараах байдлаар үнэлгээ хийлээ.

### 3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

СТЗТҮИтХ-ийн үндсэн зорилтыг “стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн уг хуулийн 1 дүгээр зүйлд заажээ. Энэхүү зорилтыг хуулийн бүхий л зохицуулалт хангаж байх ёстой гэж үзэж байна. Иймд тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн зохицуулалт тус бүр үнэлгээ хийхээр сонгож авсан болно.

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.** СТЗТҮИтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт зорилгодоо хүрсэн эсэх?

#### **7 дугаар зүйл.Стандартчиллын зорилго**

7.1.Стандартчиллын зорилго нь бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал, харилцан орлуулалт болон сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

СТЗТҮИтХ-ийн 7 дугаар зүйлээр Стандартчиллын зорилгыг зохицуулсан бөгөөд тус зүйлийн 1 дүгээр хэсэгт “Стандартчиллын зорилго нь бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал, харилцан орлуулалт болон сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж заасан. Тухайн хэсгийг тайлбарлавал Стандартчиллын зорилго нь

1. **Бүтээгдэхүүн хэрэглээний нийцтэй байдлыг хангах гэж аливаа материал, бүрдэл хэсэг, тоног төхөөрөмж, тогтолцоо, тэдгээрийн нийцэл.** Жишээ нь: Дэлхийн аль ч оронд үйлдвэрлэсэн сэлбэг, техник хэрэгсэл 1 стандартаар үйлдвэрлэгдсэн хоорондоо таарч тохирох,
2. **Харилцан орлуулалт гэж салбар чиглэлээсээ хамааран бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд харилцан орлуулалт гэдэг үгийг сонгож хэрэглэнэ.** Ерөнхийдөө бүтээгдэхүүний нийцтэй байдалтай ижил утгатай,
3. **Сорилт хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар нөөцийг зүй зохистой ашиглах гэж олон Улсын хэмжээнд аль ч лабораторийн сорилтын дүн ижил байна.** Мөн хэмжиж буй нэгж нь адил байна. Жишээлбэл: (Сантиметр – Инч биш зөвхөн Сантиметр),

4. **Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх** гэж стандартын шаардлагыг хангаж үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нь зах зээлд нийлүүлэгдэхдээ бусад ижил төрлийн бүтээгдэхүүнээс илүү давуу байдалтай борлуулагдах, худалдан авагчийн итгэлийг нэмэгдүүлэх
5. **Худалдааг нэмэгдүүлэх:** стандартын шаардлагыг хангаж үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нь зах зээлд нийлүүлэгдэхдээ бусад ижил төрлийн бүтээгдэхүүнээс илүү давуу байдалтай борлуулагдах, худалдан авагчийн итгэлийг нэмэгдүүлэхийг ойлгоно.

Мөн тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт "Стандартчилал" гэж бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний харилцан орлолт, аюулгүй байдал, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нийцтэй, нэгдмэл байдлыг хангах зорилгоор нийтлэг бөгөөд дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг хэлнэ" гэж тодорхойлсон. Тайлбарлавал стандартчилал нь стандарт тогтоох үйл ажиллагаа буюу тухайн баримт бичгийг үйлдэх, боловсруулах үйл явцыг хэлж байна.

Дээрх стандартчиллын тодорхойлолтын дагуу стандартын баримт бичиг нь тогтмол боловсруулагдан, батлагдаж байна. Гэвч тэдгээрийн хэрэгжилт, стандартчиллын зорилгын биелэлт төдийлөн хангалттай бус байна. Тодруулбал:

1. Стандартын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг учир олон нийт, хэрэглэгчдийн зүгээс хэрэгжүүлэх хяналт, гомдол хангалтгүй байна.

#### ***Шигтгээ 1.***

Иргэд, байгууллагууд стандартын талаар анхан шатны ойлголт, мэдлэгтэй байх нь стандартын хөгжлийг хурдасгах гол түлхэц болно. Менежментийн тогтолцооны аудиторудыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулдаг сургалтын байгууллагуудыг гэрчилгээжүүлэх, өндөр шалгуураар албан ёсны зөвшөөрөл олгодог байх шаардлагатай байна<sup>1</sup>

*"Олон улсын стандартын академи" ХХК-ийн мэргэжилтнүүд*

#### ***Шигтгээ 2.***

Стандартыг мөрдөх талаар иргэд, аж ахуйн нэгж байгууллын ойлголт маш хомс бөгөөд нөгөө талаас стандартыг мөрдсөнөөр зардал нэмэгддэг тул аль болох их ашиг олж стандартгүй бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхийг аж ахуйн нэгжүүд эрмэлзэж байна. Сургалт, мэдээлэл арга зүйгээр хэн, хэзээ, хэрхэн хангах нь тодорхойгүй байна<sup>2</sup>

*"Хотын Стандарт хяналтын газар"-ын мэргэжилтнүүд*

#### ***Шигтгээ 3.***

<sup>1</sup> 2022 оны 10 дугаар сарын 05-ны Стандарт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж гарсан. Тухайн захирамжийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын хуулийн холбогдох оролцогч нарыг хамруулан хуулийн хэрэгжилтэд санал авсан байдаг. Тухайн саналын хүрээнд "Олон улсын стандартын академи" ХХК-с ирсэн санал.

<sup>2</sup> 2022 оны 10 дугаар сарын 05-ны Стандарт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж гарсан. Тухайн захирамжийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын хуулийн холбогдох оролцогч нарыг хамруулан хуулийн хэрэгжилтэд санал авсан байдаг. Тухайн саналын хүрээнд "Хотын Стандарт хяналтын газар"-с ирсэн санал.

Стандартын мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, Стандарт, тохирлын үнэлгээ, итгэмжлэл, хэмжил зүйн талаар олон нийтэд мэдлэг, мэдээлэл түгээх хэрэгтэй<sup>3</sup>

*“Увс аймаг дахь стандарт, хэмжил зүйн хэлтэс”-ийн мэргэжилтнүүд*

#### **Шигтгээ 4.**

Түүнчлэн [www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn) цахим хуудаснаас зарим төрлийн стандартыг харахад дэлгэрэнгүй харах боломжгүй байдаг учир бүх стандартыг интернэтээс дэлгэрэнгүй харахаар ил тод байлгах зохицуулалт хийх, бүх төрлийн стандартыг үнэгүй болгох талаар тодорхой заалт тусгах шаардлагатай байна.

Өндөр хөгжилтэй улс орнууд тэр дундаа Европын холбооны гишүүн улс орнуудын стандартчиллыг хэрэгжүүлэх, чанарын хяналтын тогтолцоон дахь зах зээлийн хяналтын нэг бүрдэл нь иргэд, хэрэглэгчдийн гомдолд суурилдаг.<sup>4</sup> Улмаар иргэд, хэрэглэгчдэд бий болсон хохирлыг барагдуулах, зөрчлийг арилгах, зах зээлээс бараа, үйлчилгээг татах талаар арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Гэвч манай улсад иргэд, олон нийтээс тавих хяналт, гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хөгжөөгүй, шүүхээс энэ чиглэлээр хэрэг, маргаан шийдвэрлэсэн туршлага төдийлөн хангалтгүй байна.

#### **2. Стандартыг нэвтрүүлэх, мөрдүүлэх талаар.**

#### **Шигтгээ 5.**

Сүүлийн жилүүдэд зарим хууль, дүрэм, журмуудад Олон Улсын стандартыг мөрдөх, хэрэгжүүлэх талаар зааж байгаа нь сайшаалтай байна. Жишээ нь: ISO 50001:2018 Эрчим хүчний менежментийн тогтолцоо, ISO27001:2021 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартуудыг хэрэгжүүлэх талаар холбогдох хууль журмуудад тусгагдаад байна. Гэвч энэ тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Тухайлбал: Хүнсний салбарт хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO22000:2018 Стандарт, барилга, уул уурхайн салбарт хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын ISO45001:2018 стандарт, төрийн бүх шатны байгууллагуудад авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO37001:2016 стандартыг заавал хэрэгжүүлэх талаар холбогдох хууль, дүрэм журмуудад тусгах шаардлагатай.

*“Олон улсын стандартын академи” ХХК-ийн мэргэжилтнүүд*

Монгол Улсын хувьд 1990 оноос өмнө аливаа стандартыг заавал дагаж мөрдүүлэх, түүнийг хянах тогтолцоог хэрэгжүүлдэг зах зээлийн орчин, соёлтой байсан. Тус тогтолцоог одоо ч зарим нэг мэргэжилтнүүд буцаан сэргээх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа нь ажиглагдсан.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгаар стандартыг “4.1.2.“стандарт” гэж ... сонгон хэрэглэх баримт бичиг” гэж, “12.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ.” гэж, “13.2.Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна.” гэж тус тус заасан.

Дээрх өөрчлөлтийн дагуу олон улсын жишгийн дагуу стандарт нь сонгон хэрэглэх баримт бичиг гэх агуулгатай болсон. Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний нарийвчилсан ангиллын дагуу батлагдсан стандартуудаас сонгон хэрэглэх боломжийг нээлттэй байлгах нь зүйтэй

<sup>4</sup> Ensuring Quality to Gain Access to Global Markets A Reform Toolkit Martin, Kellermann, 2019

бөгөөд хэрэглэгч, худалдан авагч тал өөрсдийн хэрэгцээнд тохирохуйц стандартыг гэрээндээ тусган худалдан авалт хийх зарчмыг олон улсад нийтлэгээр мөрдөж байна. Харин хуулийн 13.2-д заасны дагуу заавал тохирлын үнэлгээнд хамрагдах эсвэл хэрэглэгч, худалдан авагч өөрөө сонгон ашиглаж буй стандартын шаардлага хангасан эсэхийг тодорхойлох ёстой тохирлын үнэлгээний байгууллагууд зах зээл дээр хангалттай хэмжээнд хөгжөөгүй байна.

### 3. Тохирлын үнэлгээний байгууллагын хөгжил дутмаг байна.

#### **Шигтгээ 6.**

Тохирлын үнэлгээний байгууллагуудыг олшруулах. Мөн сонгохдоо нээлттэй сонгон шалгаруулалт хийдэг, чанартай байх<sup>5</sup>

*“Мэргэжлийн хяналтын ерөнхий газар”-ын мэргэжилтнүүд*

#### **Шигтгээ 7.**

Стандартын хэрэгжилтийг яаж хангуулах вэ гэдэг дээр л анхаарал хандуулъя. Тэр тохирлын үнэлгээний байгууллагуудыг гаргая гэдэг бол зөв. Гэвч тохирлын үнэлгээний байгууллага яагаад гарч чадахгүй байна гэдэг асуулт гарна. Учир нь өрсөлдөөн буюу төр тэрийгээ хийгээд байгаа юм. Тэгэхлээр төрийг болиулах тогтолцоо руу л оруулах хэрэгтэй юм шиг байгаа юм.<sup>6</sup>

*“Үндэсний итгэмжлэлийн төв”-ийн мэргэжилтнүүд*

Европын холбооны гишүүн улс орны Засгийн газар нь хууль, тогтоомжоор гуравдагч талын гэрчилгээжүүлэлт шаардлагатай тохиолдолд тохирлын үнэлгээ явуулах байгууллагуудыг нэр зааж тодорхойлох жишиг байдаг боловч сүүлийн жилүүдэд тохирлын үнэлгээ явуулах байгууллагыг итгэмжлэлд хамруулах замаар чадавхыг нотлох хандлага бий болсон.

Тохирлын үнэлгээг төр дангаараа гүйцэтгэх бус хувийн хэвшилд тулгуурлах, тухайлбал төрийн байгууллагаас хийх тохирлын үнэлгээний үйл ажиллагааны зарим хэсгийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зэргээр хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх бодлогыг улс орнууд баримталж байна. Үндэсний итгэмжлэлийн төвийн цахим хуудсанд бүртгэлтэй итгэмжлэгдсэн 159 байгууллагын 97 нь төрийн байгууллага эсвэл төрийн оролцоотой компанийн харьяанд байна.

Хуулийн дагуу хувийн хэвшлийн тохирлын үнэлгээний байгууллагууд үүсэж хөгжих боломжтой боловч дээрх төрийн мэдлийн тохирлын үнэлгээний үйл ажиллагаатай үнэ, зах зээлийн хувьд өрсөлдөх боломж хязгаарлагдмал байна. Түүнчлэн стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн төрийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагчийг тухайлан заасан нь Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн агуулгатай давхардсан байхаас гадна хуулийн 29.2.2-д “энэ хуулийн 13.2-т заасан бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулсан эсэхэд хяналт тавих” гэсэн нь тохирлын үнэлгээний үр дүнг бус тохирлын үнэлгээний процессыг зааж өгсөн нь агуулгын хувьд ойлгомжгүй байдлыг үүсгэсэн байх талтай байна. Түүнчлэн хуулийн 13.2-д заасан заавал

<sup>5</sup> 2022 оны 10 дугаар сарын 05-ны Стандарт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж гарсан. Тухайн захирамжийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын хуулийн холбогдох оролцогч нарыг хамруулан хуулийн хэрэгжилтэд санал авсан байдаг Тухайн саналын хүрээнд “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар”-с ирсэн санал.

<sup>6</sup> “Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн “Үндэсний итгэмжлэлийн төв”-ийн төлөөллөөс гаргасан санал 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэл 15-р тал

тохирлын үнэлгээнд хамруулсан байх шаардлагатай бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд нийлүүлэгчийн мэдэгдэл гаргасныг тохирлын үнэлгээнд хамруулсанд тооцох эсэх нь тодорхой бус байна.

Дээрхээс дүгнэвэл СТЗТИҮТХ-д хуульд тусгагдсан стандартчиллын зорилго нь зорилгодоо хүрэх хэмжээнд хангалттай хэрэгжиж чадахгүй байх тул тухайн зохицуулалтыг эргэн харах зайлшгүй шаардлагатай болсныг илтгэж байна.

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2.** СТЗТИҮТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт зорилгодоо хүрсэн эсэх?

**13 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний зорилго, хамрах хүрээ**

13.1. Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад оршино.

СТЗТИҮТХ 13 дугаар зүйлд Тохирлын үнэлгээний байгууллагын зорилгыг тодорхойлон зохицуулсан бөгөөд тус зүйлийн 1 дүгээр хэсэгт "Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад оршино" гэж заасан. Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7. "тохирлын үнэлгээний байгууллага" гэж энэ хуулийн 4.1.6-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий байгууллагыг, 4 дүгээр зүйлийн 4.1.6. "тохирлын үнэлгээ" гэж бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Практикт тохирлын үнэлгээний байгууллага нь тохирлын үнэлгээ хийлгэхээр хүссэн байгууллагын хүсэлтийн дагуу тухайн бараа, бүтээгдэхүүн, ажилтны ур чадварыг стандарт, техникийн зохицуулалтыг хангасан эсэхийг хянаж, дүгнэлт гаргадаг байгууллага байна. Гэтэл хуульд тохирлын үнэлгээний байгууллага нь тохирлын үнэлгээ хийхээс гадна нэмэлтээр бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах ёстой байна.

СТЗТИҮТХ нь 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр шинэчлэгдэн батлагдаж, 2018 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн байдаг. Гэвч тухайн хууль батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш өдийг хүртэлх хугацаанд Тохирлын үнэлгээний байгууллага нь дээрх зорилгуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн тодорхой бус байна. Тодруулбал: Хуульд Тохирлын үнэлгээний байгууллагыг дээрх зорилго тус бүрийг хангах хэмээн тодорхойлсон боловч тухайн зорилгыг хангахын тулд хэрхэн ажиллах талаар холбогдох зохицуулалтыг нарийн тодорхой тусгаагүйгээс үүдэлтэйгээр хэрэгжих механизм нь алдагдсан байна. Тухайлбал:

***Шигтгээ 7.***

2019 оноос стандартыг хэрэгжүүлэх гээд явж ажиллаж байгаа. Хэрэгжилтийг хангуулах гэдэг дээр хэн хэзээ яаж хангуулах талаар чиг үүргийг тодорхой тусгаж өгөх шаардлагатай гэж бодож байна. Тохирлын үнэлгээний байгууллагаар хийлгэх гэж оролдож байсан. Яаж хийх вэ, хэн бид нарыг үнэлэх эрхзүйн зохицуулалт тодорхойгүй байдаг. Нийтээрээ ямар ч стандарт норм дүрмийг хэрэгжүүлнэ гэдэг үүрэг хариуцлага юм уу ухамсар байдаггүй, ААН зүгээр би нэг ийм ажил хийх гэж байгаа хувь хүнийхээ мэдрэмжээр ч юм уу ямар нэгэн хэм хэмжээ тавьчихсан байдаг шаардлага байдаг гэдгийг

мэдэхгүй. Тийм учраас хэм хэмжээний тухай ойлголтыг өгч байх хэрэгтэй юм байна гэж ойлгосон<sup>7</sup>

*“Хотын стандартын газар”-ын мэргэжилтнүүд*

#### **Шигтгээ 8.**

Стандартыг тохирлын үнэлгээний байгууллагууд, техникийн зохицуулалтыг төрийн хяналтаар хийх нь зүйтэй гэх саналтай нэг байр суурьтай байна. Үүнийг хуулиар нарийвчлан тусгах шаардлагатай<sup>8</sup>

*“Мэргэжлийн хяналтын ерөнхий газар”-ын мэргэжилтнүүд*

#### **Шигтгээ 9.**

Тохирлын үнэлгээний байгууллага зах зээлийг нь гаргаад өгчихвөл борооны дараах мөөг шиг гараад л ирнэ. Тэгэхээр бид нар хууль эрх зүйгээрээ тохирлын үнэлгээний байгууллагуудыг бий болгох, энэ орон зайг нь бэлдэж өгөх нь л энэ хууль тогтоомж болон стандартын хэрэгжилтийн орон зай гэж харж байгаа юм аа<sup>9</sup>

*“Ногоон титэм” ТББ-ын мэргэжилтнүүд*

#### **Шигтгээ 10.**

Стандартын хэрэгжилтэд хэн хяналт тавих вэ. Гүйцэтгэх засаглалын дотоод хяналтын тухай хуулийн төсөл өргөн баригдсаныг та бүхэн мэдэж байгаа. Үүнд хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага буюу салбарын яамд буюу холбогдох төрийн захиргааны байгууллагууд, мөн тохирлын үнэлгээний байгууллага, мэргэжлийн холбоодоор дамжуулан стандартын хэрэгжилтийг хангахаар байгаа. Энэ тогтолцоог бид хууль эрхзүйг боловсронгуй болгох хүрээндээ оруулья<sup>10</sup>

*“Стандарт, хэмжил зүйн газар”-ын мэргэжилтнүүд*

Олон улсад тохирлын үнэлгээний зорилгыг тодорхойлохдоо зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хууль, тогтоомжид заасан шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох үйл ажиллагаа гэж томъёолсон байдаг. Гэвч СТЗТИҮТХ-д хуулиар зорилгыг олон улсын жишгээс зөрүүтэй томъёолжээ. Цаашилбал тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэлд хамруулах, итгэмжлэгдсэн байгууллагаас гаргасан дүгнэлт, гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрч, худалдааг хөнгөвчлөх ерөнхий зарчмыг ДХБ-ын гишүүн орнууд хэрэгжүүлж байна.

Дээрхээс дүгнээд үзвэл СТЗТИҮТХ-д хууль тусгагдсан Тохирлын үнэлгээний зорилго нь зорилгодоо хүрэх хэмжээнд хангалттай хэрэгжих нөхцөл бүрдээгүй, холбогдох зохицуулалтууд тодорхой бус байх тул тухайн зохицуулалтыг эргэн харах зайлшгүй шаардлагатай болсныг илтгэж байна.

<sup>7</sup> “Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн “Хотын стандартын газар”-ын төлөөллөөс гаргасан санал 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэл 7-р тал

<sup>8</sup> “Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар”-ын төлөөллөөс гаргасан санал 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэл 8-р тал

<sup>9</sup> “Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн “Ногоон титэм” ТҮБ-ын төлөөллөөс гаргасан санал 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэл 11-р тал

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3.** СТЗТҮИТХ-ийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг зорилгодоо хүрсэн эсэх?

**16 дугаар зүйл.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго**

16.1.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго нь худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах, худалдааг хөнгөвчлөх, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний дүнг олон улс, бус нутаг, гадаад улс болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

СТЗТҮГТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1-т "Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго нь худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах, худалдааг хөнгөвчлөх, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний дүнг олон улс, бус нутаг, гадаад улс болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино" гэж заасан. Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь хэсэгт "тохирлын үнэлгээний итгэмжлэл" гэж эрх бүхий байгууллагаас тохирлын үнэлгээний байгууллага нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн чадвартайг тогтоож, хүлээн зөвшөөрөх ажиллагааг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Тохирлын үнэлгээний итгэмжлэл нь хуулийн тодорхойлолтод тусгагдсан үндсэн чиг үүргээс гадна зорилгод тусгагдсан чиг үүргийг давхар гүйцэтгэх ёстой байна. Гэвч тухайн тохирлын үнэлгээний итгэмжлэл нь тодорхойлолтын хүрээнд тусгагдсан чиг үүргээ гүйцэтгэх боловч зорилгын хүрээнд тодорхой хийж гүйцэтгэсэн ажил тодорхой бус байна. Тодруулбал: СТЗТИҮТХ хэрэгжиж эхэлснээс хойш Тохирлын үнэлгээний итгэмжлэл нь Худалдаан дахь саад тотгорыг арилгах, худалдааг хөнгөвчлөх, Бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх гэх зорилтуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил тодорхой бус, үр дүнд хүрсэн нийтэд нээлттэй ажил хийгдээгүй байна. Мөн хуульд тухайн зорилгын хүрээнд олгосон эрх хэмжээг хэрхэн хэрэгжүүлж, гүйцэтгэх тухай тодорхой холбогдох нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байгаа хэрэгжих нөхцөлийг үгүйсгэж байна.

Түүнчлэн тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа Үндэсний итгэмжлэлийн төв нь төрийн албан байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа нь нэг талаар хүний нөөцийн боломж чадавхын хувьд хангалттай хэмжээнд хүрч хөгжөөгүй, нөгөөтээгүүр зорилгод тусгагдсан гадаад харилцааг хөгжүүлэх, худалдааг хөнгөвчлөх чиглэлд статусын хувьд хангалтгүй байна. Иймд СТЗТИҮТХ-д хууль тусгагдсан Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго нь зорилгодоо хүрэх хэмжээнд хангалттай хэрэгжих нөхцөл холбогдох зохицуулалтууд тодорхой бус байх тул тухайн зохицуулалтыг эргэн харах зайлшгүй шаардлагатай байна.

Европын холбоо, Япон, Герман улсуудын хувьд тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллагыг нэгтгэх, чадавхыг нэмэгдүүлэх бодлогыг баримталж байна. Европын парламентын 2008 оны 765 дугаар чиглэлээр гишүүн улс орнууд нэг итгэмжлэлийн байгууллагатай байх, ашгийн төлөө бус зорилгоор үйл ажиллагаа явуулах, мөн тус байгууллага нь тохирлын үнэлгээ хийхгүй байх эсвэл тохирлын үнэлгээний байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэхгүй байх үндсэн зарчмуудыг тогтоосон байдаг.

**3.2. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:**

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.** СТЗТҮИТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэг хүлээн зөвшөөрөгдсөн эсэх? Өөрөөр хэлбэл хууль тогтоомжийн холбогдох зохицуулалтыг

нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.1."стандартчилал" гэж бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг;

СТЗТҮИТХ 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "стандарт" гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг гэж заасан бөгөөд тус хуулийн 12 дугаар зүйлийн 1-т "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ" гэж тусгагдсаны дагуу стандартыг сонгон хэрэглэхээр тусгасан байна. Гэвч нийгэмд стандартыг сонгон хэрэглэх тухай ойлголт харилцан адилгүй байна. Тухайлбал:

#### **Шигтгээ 11.**

Хуулийн заалтын дагуу сонгон хэрэглэх гэдэг нь тухайн стандартыг хэрэглэх эсэхийг сонгоно гэж заасан байхад стандартын хэрэгжилтийг үнэлдэг байгууллагууд заавал хэрэглэх эрхзүйн баримт бичиг гэсэн ойлголттой байдаг<sup>11</sup>

*"Эрүүл мэндийн яам"-ын мэргэжилтнүүд*

#### **Шигтгээ 12.**

СТЗТҮИТ хуулийн 12.1-д "Иргэн аж ахуй нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ" заасныг дараах байдлаар тайлбарлаж байна.

1. Стандарт нь зөвлөмжийн баримт бичиг, иргэн, аж ахуй нэгж, байгууллага хэрэглэх эсэхээ сонгох тухай ойлголт /СХЗГ-ын мэргэжилтний тайлбар/

*"Боловсрол, шинжлэх ухааны яам"-ын мэргэжилтнүүд*

#### **Шигтгээ 13.**

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд техникийн зохицуулалтыг заавал, стандартыг сонгон хэрэглэхээр заасан ч заавал хэрэгжүүлэх техникийн зохицуулалтыг батлан гаргах эрх бүхий байгууллагаас батлаагүй байгаа нь хууль батлагдан гарсан цагаасаа хэрэгжих боломжгүй нөхцөлийг үүсгэж байна. Стандартыг хууль тогтоомж, гэрээнд тусгаснаар хэрэгжинэ гэж байгаа боловч тусгаагүй тохиолдолд хэрэгжихгүй эсвэл сонгон хэрэглэх гэсэн учир хэрэглэх албагүй гэсэн хандлагыг бий болгосон. Энэ нь Монгол Улсын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал хангагдахгүй байх үндэс болж байна<sup>12</sup>

*"Хотын стандарт, хөгжлийн газар"-ын мэргэжилтнүүд*

<sup>11</sup> 2022 оны 10 дугаар сарын 05-ны Стандарт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж гарсан. Тухайн захирамжийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газраас хуулийн холбогдох оролцогч нарыг хамруулан хуулийн хэрэгжилтэд бичгээр санал авсан байдаг. Тухайн саналын хүрээнд "Эрүүл мэндийн яам"-с ирсэн санал.

<sup>12</sup> 2022 оны 10 дугаар сарын 05-ны Стандарт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж гарсан. Тухайн захирамжийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газраас хуулийн холбогдох оролцогч нарыг хамруулан хуулийн хэрэгжилтэд бичгээр санал авсан байдаг. Тухайн саналын хүрээнд "Хотын стандарт, хөгжлийн газар"-с ирсэн санал.

**Шигтгээ 14.**

Аж ахуй нэгж, иргэн нь стандартыг сонгон хэрэглэх гэсэн заалтыг тодорхой болгох<sup>13</sup>

“Сүхбаатар аймаг дахь стандарт, хэмжил зүйн хэлтэс”-ийн мэргэжилтнүүд

Дээрхээс дүгнээд үзвэл СТЗТИҮтХ-д хууль тусгагдсан стандартын тодорхойлолтын сонгон хэрэглэх гэх ойлголт нь хоёр өөр ойлголтыг бий болгохуйц тодорхойлогдсон байх тул хангалттай хэрэгжих нөхцөл болон тус зохицуулалтын нийгэмд хүлээн зөвшөөрөгдөн хэрэгжих боломжийг алдагдуулж байна. Иймд тухайн зохицуулалтыг эргэн харах зайлшгүй шаардлагатай болсныг илтгэж байна.

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2.** СТЗТҮИтХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг хүлээн зөвшөөрөгдсөн эсэх? Өөрөөр хэлбэл хууль тогтоомжийн холбогдох зохицуулалтыг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.

СТЗТҮИтХ-н 14 дүгээр зүйлийн 14.1-т “Тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна” гэж заасан бөгөөд тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт “Тохирлын гэрчилгээг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага олгоно” гэж тусгагдсан байна. Хуульд тусгагдсан чиг үүргийн хүрээнд итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага сүүлийн 4-7 жилийн хугацаанд дор тусгагдсаны дагуу тохирлын гэрчилгээг олгосон байна.

**1. Тогтолцооны баталгаажуулалтын баталгаажуулалт:**

Хүснэгт 1.

| Он      | Гэрчилгээжсэн аж ахуйн нэгжийн тоо /өссөн дүнгээр/ | Менежментийн тогтолцооны төрлөөр ангилбал |           |           |           |           |       |
|---------|--|---|-----------|-----------|-----------|-----------|-------|
|         |  | ISO 9001                                  | ISO 22000 | ISO 45001 | ISO 14001 | ISO 50001 | НАССР |
| 2016    | 101  | 98  | 2         | -         | 1         |           | 0     |
| 2017    | 125  | 117                                       | 2         | -         | 3         |           | 3     |
| 2018    | 164  | 147                                       | 7         | -         | 4         |           | 6     |
| 2019    | 181  | 161                                       | 10        | 1         | -         |           | 9     |
| 2020    | 209  | 177                                       | 12        | 4         | 6         |           | 10    |
| 2021    | 240  | 200                                       | 15        | 7         | 7         |           | 11    |
| 2022.10 | 258  | 210                                       | 15        | 13        | 8         | 1         | 11    |

**2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт:**

Дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон байдал (Төв болон орон нутгийн салбарын хэмжээнд)

Хүснэгт 2.

<sup>13</sup> 2022 оны 10 дугаар сарын 05-ны Стандарт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж гарсан. Тухайн захирамжийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газраас 21 аймгийн стандарт хэмжил зүйн хэлтэс тус бүрээс хуулийн хэрэгжилтэд бичгээр санал авсан байдаг. Тухайн саналын хүрээнд “Сүхбаатар аймаг дахь стандарт, хэмжил зүйн хэлтэс”-с ирсэн санал.

| Он      | Нийт Аж ахуйн нэгж /давхардсан тоогоор/ | Нийт олгосон гэрчилгээ | Бүтээгдэхүүнд олгосон гэрчилгээ | Үйлчилгээнд олгосон гэрчилгээ |
|---------|---|------------------------|---------------------------------|-------------------------------|
| 2016    | 3685                                    | 3738                   | 300                             | 3438                          |
| 2017    | 4209                                    | 4260                   | 308                             | 3952                          |
| 2018    | 4450                                    | 4541                   | 355                             | 4186                          |
| 2019    | 3874                                    | 3932                   | 322                             | 3610                          |
| 2020    | 2798                                    | 2812                   | 226                             | 2586                          |
| 2021    | 3215                                    | 3322                   | 355                             | 3357                          |
| 2022.10 | 3342                                    | 3347                   | 302                             | 3045                          |

3. Экспортын бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгосон байдал:

Хүснэгт 3.

| Он      | Аж ахуй нэгжийн тоо /давхардсан тоогоор/ | Олгосон гэрчилгээний тоо | Бүтээгдэхүүний нэр төрөл |
|---------|--|--------------------------|--------------------------|
| 2016    | 754                                      | 1326                     | Багцалсан 8 нэр төрөл    |
| 2017    | 813                                      | 1755                     | Багцалсан 8 нэр төрөл    |
| 2018    | 1042                                     | 2490                     | Багцалсан 8 нэр төрөл    |
| 2019    | 1406                                     | 3403                     | Багцалсан 8 нэр төрөл    |
| 2020    | 712                                      | 2462                     | Багцалсан 8 нэр төрөл    |
| 2021    | 1205                                     | 2242                     | Багцалсан 8 нэр төрөл    |
| 2022.10 | 361                                      | 1163                     | Багцалсан 8 нэр төрөл    |

4. Импортын бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгосон байдал:

Хүснэгт 4.

| Он      | Аж ахуй нэгжийн тоо /давхардсан тоогоор/ | Олгосон гэрчилгээний тоо | Бүтээгдэхүүний нэр төрөл |
|---------|--|--------------------------|--------------------------|
| 2016    | 50                                       | 58                       | 76 нэр төрөл             |
| 2017    | 56                                       | 72                       | 84 нэр төрөл             |
| 2018    | 75                                       | 86                       | 97 нэр төрөл             |
| 2019    | 64                                       | 83                       | 105 нэр төрөл            |
| 2020    | 99                                       | 108                      | 170 нэр төрөл            |
| 2021    | 107                                      | 122                      | 180 нэр төрөл            |
| 2022.10 | 161                                      | 161                      | 140 нэр төрөл            |

5. Аюулгүйн тэмдгийн гэрчилгээ олгосон байдал:

| Он   | Аж ахуй нэгжийн тоо /давхардсан тоогоор/ | Олгосон гэрчилгээний тоо | Бүтээгдэхүний нэр төрөл |
|------|--|--------------------------|-------------------------|
| 2019 | 9  | 9                        | 76 нэр төрөл            |
| 2020 | 4  | 4                        | 35 нэр төрөл            |
| 2021 | 2  | 2                        | 12 нэр төрөл            |
| 2022 | 6  | 6                        | 114 нэр төрөл           |

Судалгаанаас үзэхэд 2016-2022 онд жилд дунджаар 20-30 ААН, байгууллагад менежментийн тогтолцооны стандартаар аудит хийж гэрчилгээжүүлсэн байна. 2022 онд 1 аж ахуйн нэгжид Эрчим хүчний менежментийн тогтолцоо. ISO 50001 стандартыг хэрэгжүүлснийг баталгаажуулж гэрчилгээжүүлсэн байна.

Стандарт, хэмжил зүйн салбарын хэмжээнд дотоодын бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтыг жилд дунджаар 3500 үйлчилгээ, 311 бүтээгдэхүүнд Тохирлын гэрчилгээ олгосон байна.

Өөрөөр хэлбэл тохирлын гэрчилгээг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага олгох чиг үүргийнхээ хүрээнд тогтмол олгон, практикт тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж тогтвортой ажиллаж буй нь дээрх статистик мэдээллээр харагдаж байна.

Гэвч СТЗТҮИтХ-д итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагад холбогдох 2 зохицуулалт тусгагдсан байна. Тухайн тусгагдсан зохицуулалтын хүрээнд итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага гэж хэнийг, юуг хэлж буй нь тодорхой бус, тохирлын гэрчилгээг ямар шалгуурыг үндэслэж, хэрхэн, хэн баталгаажуулж гэрчилгээг олгох гэх мэт бүхий л холбогдох нарийн асуудлуудыг хөнддөггүй байна. Үүнээс үүдэлтэйгээр нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх үндэслэл нь үгүйсгэгдэж байна.

Иймд СТЗТИҮтХ-д хууль тусгагдсан Тохирлын гэрчилгээг олгох итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын ойлголт тодорхой бус байх тул тухайн зохицуулалтыг эргэн харах зайлшгүй шаардлагатай байна.

### 3.3. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. СТЗТҮИтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн зохицуулалт практикт хэр нийцсэн бэ?**

**25 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага**

25.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төрөөс стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, эрхэлсэн асуудлын хүрээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Засгийн Газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар нь анх 1923 онд Жин хэмжүүрийн товчоо нэртэйгээр байгуулагдсанаас хойш өдгөө үндсэн 8 нэгж, 1 алба мөн орон нутгийн 20 аймагт салбар хэлтэстэй, салбарын хэмжээнд 420 гаруй ажилтан,

албан хаагчид бүхий Засгийн Газрын тохируулагч агентлаг болтлоо хөгжлийн олон үеийг туулж ирсэн 100 жилийн түүхтэй байгууллага юм.

#### **Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг:**

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, стандартчилал, тохирлын үнэлгээний баримт бичгүүдийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, үндэсний стандартыг олон улсын стандартын түвшинд хүргэж нэмэгдүүлэх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд стандартчиллын бодлогоор дэмжлэг, тусалцаа үзүүлэх, олон улс, бүс нутаг, 2 талын стандартчиллын хамтын ажиллагааг хөгжүүлэх, стандартчиллын техникийн хороод болон дэд хороодын үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, тохирлын үнэлгээний бодлогыг тодорхойлох;
- Хэмжил зүйн тухай хууль, эрх зүйн орчныг олон улсын жишиг, улс орны нийгэм эдийн засгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох санал боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх, хэмжлийн эталоныг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын болон хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга хийх ажилтны чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын эрх олгох, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг хөтлөх, улсын эталон, стандартчилсан загварыг бий болгох, зохион бүтээх, хадгалах, харьцуулан дүйлгэж баталгаажуулах, хэмжил зүйн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил, туршилт хийх, улсын эталоны нэгж дамжуулалтыг олон улсад болон үндэсний хэмжээнд хангах, өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх, хэмжил, шалгалт тохируулгын чадавхыг Жин, хэмжүүрийн олон улсын байгууллагын мэдээллийн санд бүртгүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, хэмжих хэрэгслийн загварын туршилт хийх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хялбаршуулах, боловсронгуй болгох, хэмжлийн нэгжийн эталоны ашиглалт, хөтлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг эталоны нэгдсэн лаборатори, секторын тогтолцоонд үндэслэн хийх, хэмжил зүйн олон улсын байгууллага, хэлэлцээрт нэгдэн орох, тэдгээртэй хамтран ажиллах чиг үүрэг хэрэгжүүлэх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг үндэсний болон олон улсын хууль, тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, аюулгүйн тэмдэг хэрэглэх бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ явуулж, гэрчилгээжүүлэх, Олон Улсын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн байгууллагад тохирлын үнэлгээ явуулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх, Баталгаажуулалтын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх улмаар тэдэнд зөв сонголт хийх, өөрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Үнэт металл, эрдэнийн чулууны үйлдвэрлэл, үйлчилгээг зохицуулсан эрх зүйн акт, сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлд химийн шинжилгээ хийж үнэт металлын сорьцыг тогтоон улсын сорьцын баталгааны тэмдэг дарах, эрдэнийн чулууг таньж гэрчилгээ олгох, сорьцын баталгааны тэмдгийн хяналт шалгалтыг хийж сорьцтой холбоотой маргааныг таслан шийдвэрлэх, шинжилгээ хийж хэрэглэгчдийн

эрх ашгийг хамгаалах, үнэт металлыг хайлж гулдмайлах, сорьцын лабораторийн чадавхыг дээшлүүлэх;


- Худалдаа үйлчилгээний тооцоо, эрүүл мэнд, байгаль орчин, улс орны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглаж байгаа хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх улмаар тэдэнд зөв сонголт хийх, өөрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулахын зэрэгцээ хуульд заасны дагуу стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар баримтлах бодлогыг боловсруулан ажиллаж байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш “Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” 2018, 2019, 2020, 2021 онуудад дараах байдлаар стандартыг шинээр баталж, хүчингүй болгож, дахин шинэчилсэн байна.

Хүснэгт 7.

| № | Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|--|------|------|------|------|
| 1 | Шинээр баталсан стандарт   | 111  | 116  | 167  | 166  |
| 2 | Хүчингүй болгосон стандарт   | 37   | 65   | 58   | 74   |
| 3 | Дахин шинэчилсэн стандарт  | 41   | 0    | 53   | 39   |
| 4 | Нэмэлт оруулсан стандарт   | 4    | 0    | 6    | 5    |

График 1.



**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2.** СТЗТҮИтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.3.4 дэх хэсгийн зохицуулалт практикт хэр нийцсэн бэ?

**25 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага**

25.3.4.хариуцсан асуудлаар олон улсын байгууллагад гишүүнээр элсэх санал гаргах, олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх;

Олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх зэрэг асуудлаар өнөөдрийн байдлаар дараах үйл ажиллагааг “*Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага*” явуулаад байна.

1. ISO /International Organization for Standardization, full member, 1979/ (Олон Улсын Стандартчиллын байгууллага)
2. IRSA /Inter-Regional Standardization Association, 1997/ (Бүс нутаг хоорондын Стандартчиллын холбоо)
3. EAFTerm /East Asian Forum on Terminology, 1998/ (Евроазийн нэр, томъёоны хурал)
4. IEC /International Electrotechnical Commission, 2000/ (Олон Улсын Цахилгаан техникийн хороо)
5. OIML /International Organization for Legal Metrology, 1998/ (Олон Улсын хууль, эрх зүйн хэмжил зүйн байгууллага)
6. APLMF /Asia Pacific Legal Metrology Forum, 1997/ (Ази, номхон далайн хууль, эрх зүйн хэмжил зүйн хурал)
7. APMP /Asia Pacific Metrology Forum, 2002/ (Ази, номхон далайн хэмжил зүйн хурал)
8. PASC /Pacific Area Standards Congress, 2002/ (Номхон далайн Стандартын конгресс)
9. CEN /European Committee for Standardization, 2011/ (Европын Стандартчиллын хороо)
10. IAOO /International Association of Assessing Officer/ (Олон Улсын Сорьцын мэргэжилтнүүдийн холбоо)
11. BIPM /International Conference of Weights and Measures, 2013/ (Олон Улсын жин хэмжүүрийн товчоо)
12. CIPM MRA /Mutual Recognition Arrangement of International Bureau of Weights and Measures, 2013/ (Олон Улсын жин хэмжүүрийн товчооны хамтарсан зохицуулалт)
13. EEC (Euroasian Economic Commission, 2017) Евроазийн Эдийн засгийн хороо

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. СТЗТҮИмХ-ийн 25 дугаар зүйлийн 25.3.6**

*дахь хэсгийн зохицуулалт практикт хэр нийцсэн бэ?*

**25 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага**

25.3.6.хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах;

Олон улсын гэрээ хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, техникийн зохицуулалт, удирдамж, зөвлөмж, аргачлал, заавар, тохирлын үнэлгээний журам болон холбогдох норматив-техникийн бусад баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хамгаалах, олон нийтэд хүргэх, мэдээлэх, хэвлэх, борлуулах үйлчилгээ үзүүлэх, төрөлжсөн сургалт зохион байгуулах замаар салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх нь Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл мөн. Энэ хүрээнд Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь 2020 онд 39 төлбөртэй сургалтыг, 2021 онд 36 төлбөртэй сургалтыг тус тус явуулсан байна. Гэвч холбогдох салбарын байгууллагуудаас сургалт хангалтгүй байгаа талаарх саналыг илэрхийлсээр байна.

Хүснэгт81.

| № | Төлбөртэй сургалтын тоо |      |
|---|-------------------------|------|
|   | 2020                    | 2021 |
| 1 | 39                      | 36   |
| 2 |                         |      |

Стандартын мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай байна гэсэн санааг холбогдох харьяа байгууллагын мэргэжилтнүүд хэлсэн байна.

**Шигтгээ 15.**

Иргэд, байгууллагууд стандартын талаар анхан шатны ойлголт, мэдлэгтэй байх нь стандартын хөгжлийг хурдасгах гол түлхэц болно. Менежментийн тогтолцооны аудиторудыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулдаг сургалтын байгууллагуудыг гэрчилгээжүүлэх, өндөр шалгуураар албан ёсны зөвшөөрөл олгодог байх

*Архангай аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс*

**Шигтгээ 16.**

Төлбөртэй ажил үйлчилгээ болон сургалт зохион явуулахад төсөвт тодорхой тусгах шаардлагатай.

*Өмнөговь аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс*

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4.** СТЗТҮИтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн зохицуулалт практикт хэр нийцсэн бэ?

**29 дүгээр зүйл. Төрийн хяналт**

29.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн төрийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллага, гаалийн байгууллага хэрэгжүүлнэ.

Стандартчиллын өнөөгийн байдлыг авч үзвэл Монгол улсад өнөөдөр хүчин төгөлдөр нийт 6525 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнээс 43 хувь нь олон улсын түвшинд хүрсэн. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн тухай хуульд яагаад өөрчлөлт оруулах болсон хэрэгцээ шаардлага бий болсон бэ гэхээр батлагдсан стандарт бүх түвшинд хэрэгждэг байх шаардлагатай бөгөөд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллага болох гаалийн байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

Төрийн хяналт шалгалтын хуулийн 9-р зүйлийн 3.1 хэсэгт хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад хяналт тавина гэсэн байдаг. Ингээд хяналт тавих үүргийг эрх зүйн актаар зааж өгсөн боловч зарим хяналт тавих шаардлагууд орхигдсон байна. Тухайлбал техникийн зохицуулалт. Ийм эрхзүйн хийдэл байгаа учраас стандартын хэрэгжилт төдийлөн хангалттай биш байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Олон улсын жишгээр стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах үүднээс ямар зохицуулалт хийх ёстой талаар цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

Эрхзүйн орчныг боловсронгуй болгоход, стандарт хэмжил зүйн газрыг шинэ түвшинд гаргахад дараах гурван үйл ажиллагаа хийх шаардлагатай хэмээн салбарын мэргэжилтнүүд санал бодлоо хэлж байна. Үүнд:

1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
2. Стандарт хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх
3. “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөр боловсруулах

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

### **5. 1 Дүгнэлт**

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээгээр хэд хэдэн дүгнэлтийг гаргаж болохоор байна. Нэгдүгээрт. Стандартыг боловсруулах, батлах процессын хувьд хуулийн холбогдох, зүйл заалтуудын хэрэгжилт харьцангуй өндөр байна. Харин хэрэглэх, мөрдөх, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зайлшгүй шаардлагатай байна.

Хоёрдугаарт. Стандартын талаарх олон нийтийн ойлголт, мэдээлэл хангалтгүй байгаа нь иргэд, хэрэглэгчдийн зүгээс шаардлага тавих, гомдол гаргах үйл ажиллагаа харьцангуй сул байна.

Гуравдугаарт. Стандартын талаарх ойлголт, түүнийг хэрэглэх асуудалд оролцогч талууд харьцангуй өөр өөр ойлголттой байгаа нь тогтоогдсон болно. Тухайлбал Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгаар стандартыг сонгон хэрэглэх баримт буюу үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь хууль, тогтоомж, эрх зүйн актаар заавал мөрдөхөөр заагаагүй бол сайн дураар хэрэглэхээр тодорхойлсон. Энэ нь олон улсын нийтлэг практикт нийцэж байгаагийн хувьд өөр өөр ойлгоход хүргэсэн ойлгомжгүй зохицуулалтыг залруулах, тодорхой болгох нь зүйтэй байна.

Дөрөвдүгээрт. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 онд батлагдсанаас хойш зах зээл дээр тохирлын үнэлгээний байгууллагууд хангалттай хэмжээнд хүрч хөгжөөгүй байгаа ба тохирлын үнэлгээний салбарт төр, төрийн оролцоотой байгууллага давамгайлсан хэвээр байна.

Тав. Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн төрийн байгууллага бий болсон боловч үйл ажиллагааны цар хүрээ, мэргэжлийн чадавх, хүний нөөц бүрдээгүй байна. Үүнд тус байгууллагын статус голчлон нөлөөлсөн байх талтай байна.

Зургаа. Тохирлын үнэлгээний байгууллагуудын талаарх тодорхойлолт, зохицуулалт хэт ерөнхий байгаа нь нарийвчилсан журам, зохицуулалтуудыг боловсруулах, батлан мөрдүүлэхэд ойлгожмгүй байдлыг бий болгосон байна.

Долоо. Төрийн хяналт, шалгалт болон тохирлын үнэлгээний хяналт, олголтын процессыг зааглах, оролцогч талуудын ойлголтыг залруулах шаардлагатай байна. Иймд тохирлын баталгаа олгох үйл ажиллагааг зөвхөн тохирлын үнэлгээний байгууллага олгох талаар илүү тодорхой болгох нь зүйтэй байна.

Найм. Тохирлын үнэлгээний итгэмжлэлд хамрагдах ач холбогдлыг сулруулсан, эрх мэдлийн тэнцвэрийг алдагдуулж, тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд салбарын сайд оролцохоор зохицуулсан нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

### **5. 2 Зөвлөмж**

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг сайжруулах хүрээнд доорх өөрчлөлтүүдийг хийх нь зүйтэй байна. Үүнд:

- Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартуудад салбарын сайдын оролцоотойгоор тогтмол хугацаанд шинжилгээ хийх;
- Стандартын тухай тодорхойлолтыг сайжруулж, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолоор эш татсан стандартыг улсын хэмжээнд заавал дагаж мөрдөх, түүнээс бусад стандартыг иргэн, аж ахуйн нэгж сонгон хэрэглэх;
- Тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд оролцогч талуудад тавигдах шаардлагыг тодорхой болгох, эрх үүргийг нарийвчлан тусгах;
- Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллагын статус, эрх хэмжээг тодорхой болгох;

- Төрийн захиргааны байгууллагаас гүйцэтгэх ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, иргэний төлөөлөл бүхий зөвлөлөөс тогтоох;
- Стандартчилал, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх хүрээнд мэдээллийн санд байршуулах мэдээллийг тодорхой болгох;
- Төрийн хяналт шалгалтаар заавал дагаж мөрдөх шаардлагатай стандартын тохирлын баталгааг хууль, тогтоомжийн дагуу гаргуулсан эсэхэд хяналт тавих зэрэг өөрчлөлтүүдийг тусгах.

## **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

### ***Хууль, эрх зүйн акт***

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Захиргааны хууль, 2013
3. Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2018
4. Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050
5. Улсын их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого
6. Улсын их хуралын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
7. Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоол
8. Засгийн газрын 2019 оны 235 дугаар тогтоол
9. Евро парламентын 2008 оны 765 дугаар чиглэл
10. Япон улсын Аж үйлдвэрийн стандартын тухай хууль
11. Евро парламентын 2012 оны 1025 дугаар чиглэл

### ***Цахим эх сурвалж***

1. <http://opendata.burtgel.gov.mn/lesinfo/8172676>
2. <https://forum.parliament.mn/projects/187>
3. <https://www.mnas.gov.mn/Use%20of%20Logos%20and%20Marks>
4. <https://emi.qcc.gov.ae/-/media/Project/QCC/EMI/Documents/TheNationalQualityInfrastructure.pdf>
5. <http://nml.gov.ph/wp-content/uploads/2013/02/THE-ANSWER-TO-THE-GLOBAL-QUALITY-CHALLENGE- A-NATIONAL-QUALITY-INFRASTRUCTURE.pdf>
6. [https://www.wto.org/english/res\\_e/booksp\\_e/tbt3rd\\_e.pdf](https://www.wto.org/english/res_e/booksp_e/tbt3rd_e.pdf)
7. [https://www.unido.org/sites/default/files/2017-02/GUIDE\\_FOR\\_THE\\_DEVELOPMENT\\_OF\\_0.pdf](https://www.unido.org/sites/default/files/2017-02/GUIDE_FOR_THE_DEVELOPMENT_OF_0.pdf)
8. <https://pubdocs.worldbank.org/en/249621553265195570/69dba889394378338787139226.pdf>
9. <https://openknowledge.worldbank.org/handle/10986/2305>

### ***Статистик мэдээ, судалгааны тайлан, ном***

1. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэл
2. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хурлын тэмдэглэл

3. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын дэд хэсгийн 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэл
4. Стандарт, тохирлын үнэлгээний бодлого хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс 2022 оны 10 дугаар сарын 05-ны Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж гарсан. Тухайн захирамжийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газар хуулийн холбогдох оролцогч нарыг хамруулан хуулийн хэрэгжилтэд авсан саналын тэмдэглэл.

**СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ  
ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ  
ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН /2024 он/**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээг Стандартчилал, тохирлын үнэлгээний хяналт зохицуулалтын тухай хуулийн төслийн холбогдох зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга<sup>2</sup> хэлбэрээр боловсруулагдсан байна.

Стандартчилал, тохирлын үнэлгээний хяналт зохицуулалтын тухай хуулийн төслийг /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>3</sup>-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН  
БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д<sup>4</sup> заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа зэрэг болно.

**Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:**

➤ **Зорилгод хүрэх байдал:**

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ.

<sup>1</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Сүүлийн нэвтрэлт 2020 оны 11 дугаар сарын 28-ны өдөр.

<sup>2</sup> 24.1.Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<sup>3</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Сүүлийн нэвтрэлт 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдөр.

<sup>4</sup> Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Ойлгомжтой байдал:**

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд<sup>5</sup> заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг<sup>6</sup> хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

## ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараахь байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

| д/д | Шалгуур үзүүлэлт             | Үр нөлөөг үнэлэх хэсэг                            | Шалгах хэрэгсэл  |
|-----|------------------------------|---|--|
| 1   | <b>Зорилгод хүрэх байдал</b> | Хуулийн төслийн холбогдох зохицуулалт             | Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.  |
| 3   | <b>Ойлгомжтой байдал</b>     | Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах | Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.    |
| 4   | <b>Харилцан уялдаа</b>       | Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах. |

<sup>5</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

<sup>6</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

## **1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:**

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Стандартчилал, тохирлын үнэлгээний хяналт зохицуулалтын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл хүчин төгөлдөр хуулийн зохицуулалтыг өргөжүүлж, дараах зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

- 1) стандартын талаарх тодорхойлолтод сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгжид төөрөгдөл, тодорхойгүй байдал үүсгэж байна. Тухайлбал, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу Засгийн газраас тохирлын үнэлгээнд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд стандартыг тодорхойлон заадаггүй нь хяналт шалгалтын нэгдмэл, ойлгомжтой байдлыг алдагдуулж байгааг өөрчлөх
- 2) Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох боломж нээлттэй боловч хувийн хэвшлийн оролцоо, эрх хэмжээг нарийвчлан тодорхойлох
- 3) итгэмжлэлийн үйл ажиллагааны үр дүнд тохирлын үнэлгээний байгууллага ажиллагаа явуулахаар заасан боловч тухай салбарт тохирлын үнэлгээг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагыг Засгийн газрын гишүүн томилж байгаа нь хувийн хэвшлийн байгууллагад шат дамжлага нэмэгдүүлсэн, зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлснийг өөрчлөх
- 4) Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох
- 5) тохирлын үнэлгээ болон тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгаж, техникийн зохицуулалт, заавал дагаж мөрдөх стандартуудын талаарх зах зээлд нийлүүлэгдэж хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхолд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны найдвартай байдал хангах

Түүнчлэн хуулийн төсөд тусгаснаар энэ хуулийн зорилт нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ түүний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалах, хяналт тавих, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг дараах байдлаар бүлэглэн шалгаж үзвэл:

1.Хуулийн төслийн 21.2 дахь заалтад “Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандартчиллын баримт бичгийг заавал дагаж мөрдөнө.” гэж заасан байна. Хэдийгээр хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан стандартын талаарх тодорхойлолтод сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгжид төөрөгдөл, тодорхойгүй байдал үүсгэж байгааг өөрчлөх зорилгод хүрэхийн тулд энэхүү заалтыг тусгасан боловч энэхүү зохицуулалт тусгасан тохиолдолд үүнтэй холбогдуулан дагалдан боловсруулах хуулийн төслүүдийг сайтар олж тогтоох шаардлага үүсэхийг анхаарч тооцох шаардлагатай.

2.Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох боломж нээлттэй боловч хувийн хэвшлийн оролцоо, эрх хэмжээг нарийвчлан тодорхойлох зорилгод хүрэх зохицуулалт нь хуулийн төслийн 7.1.6 дахь заалтад хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах”, мөн төслийн 7.1.7 дэх заалтад “стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээ хийх, энэ хуулийн 7.1.6-д заасан ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;” гэсэн заалтаар дамжих хэрэгжих боломжтой байна. Хувийг хэвшил рүү хандсан тэдний оролцоог хангасан зохицуулалт үүнээс өөр дэвшилтэт зохицуулалт байхгүй байгаад анхаарч, дээрх зохицуулалтаас гадна хуулийн төсөлд заасны дагуу байгуулах Зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн оролцоог хангах, шаардлагатай бол Худалдаа аж, үйлдвэрийн танхимын төлөөллийг оролцуулах замаар шийдвэрлэх боломжтойг анхаарах

3.Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоход зорилгод чиглэсэн зохицуулалт хангалтгүй байна. Иймд үзэл баримтлалд тусгагдсан тус зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

4.Хуулийн төслийн зохицуулалтууд нь бүхэлдээ тохирлын үнэлгээ болон тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгаж, техникийн зохицуулалт, заавал дагаж мөрдөх стандартуудын талаарх зах зээлд нийлүүлэгдэж хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхолд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны найдвартай байдал хангах зорилгод чиглэгдсэн байна гэж үзэхээр байна.

Хуулийн төслийн шинэчлэн найруулга хэлбэрээр боловсруулсан байх бөгөөд дараах давхардал, хийдэл, зөрчил үүссэн байгааг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1.Хуулийн төслийн нэрийг өөрчилсөн талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой тусгаагүй байна. Хуулийн төслийн үзэл баримтлалын нэрийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр тусгаж, харин үзэл баримтлалдаа шинээр нэрлэх хуулийн нэрийг өөрчлөн тусгах талаар тусгайлан тусгахыг анхаарах;

2.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.” гэж заасан. Хуулийн төслийн холбогдох заалтуудад стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн “төв байгууллага” гэж тусгасан нь хууль батлагдсаны дараа хууль хэрэглээнд тодорхойгүй байдал үүсдэгийг анхаарч Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн “төрийн захиргааны байгууллага” гэж хүчин төгөлдөр хуульд тусгасан агуулгыг хэвээр нь үлдээх;

3.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Агентлагийг Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup>дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилогдсон дарга тэргүүлнэ.” гэж заасан. Иймд хуулийн төслийн 6.4 дэх хэсэгт заасан “Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төв байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэж давхардуулан тусгах шаардлагагүй юм. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7 дахь заалтад “бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг

тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх” гэж заасанд нийцэхгүй болно.

4.Хүчин төгөлдөр Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.” гэж заасан. Гэтэл хуулийн төслийн 6.5 дахь хэсэгт Аймаг, нийслэлийн стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллагын даргыг Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төв байгууллагын дарга томилж, чөлөөлөхөөр тусгажээ. Өөрөөр хэлбэл аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөхгүйгээр шууд томилох асуудлыг тусгажээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн орон нутгийн хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, түүнчлэн мөн хуульд заасны дагуу нийслэлийн чиг үүрэгт стандарт хэрэгжүүлэх асуудал мөн харьяалагдаж байгааг анхаарах, мөн энэ нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй зарчмын өөрчлөлт байгааг анхаарч, шаардлагатай бол энэхүү өөрчлөлтийн талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой тусгах ;

5.Хуулийн төслийн 7.1.1 дэх заалтад Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төв байгууллага стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний дүрэм, журам, заавар, боловсруулах, батлахаар тусгажээ. Журмаар зохицуулах харилцааг аль болох хуулийн төсөлд тусгах замаар шийдвэрлэх, зайлшгүй шаардлагатай бол Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тусгайлан батлах журмын нэр, зохицуулах асуудлын тодорхой тусгах нь зүйтэй. Энэ нь хууль батлагдсаны дараа хуулийг хэрэгжүүлэх баталгааг нэмэгдүүлэх ач холбогдолтойг анхаарах;

6.Хуулийн төслийн 7.1.9. дэх заалтад “энэ хуулийн 22.1 дэх хэсэгт заасан бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хэрэгжүүлэх шинжээчид тавих шаардлагыг тогтоох, шинжээчийн эрх олгох, цуцлах”; мөн төслийн 7.1.10 дахь заалтад “стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах эрх олгох, цуцлах;” асуудлыг тусгажээ. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "зөвшөөрөл" гэж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон эрхийг; ойлгохоор заасан.

Иймд хуулийн төсөлд тусгасан дээрх үйл ажиллагаанд нь нэг төрлийн зөвшөөрөлд хамаарах үйл ажиллагаа байх тул Зөвшөөрлийн тухай хуульд “Хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно.” гэж заасныг мөн баримтлах шаардлагатай. Төсөлд тусгасан шинжээчийн эрх олгох, цуцлах асуудал нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд байгаа зохицуулалт тул Зөвшөөрлийн тухай хуульд нийцсэн зохицуулалт гэж үзэж болох юм. Харин стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах эрх олгох, цуцлах асуудлыг “зөвшөөрөл” хэлбэрт оруулахаас зайлсхийж

харин бүртгэлийн хэлбэрээр явуулж болохыг хуулиар зөвшөөрсөн тул Зөвшөөрлийн тухай хуулийн энэхүү зохицуулалтыг ашиглах;

7.Хуулийн төслийн 15.3 дах хэсэгт “Шаардлагатай тохиолдолд техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх журмыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны “шаардлагатай тохиолдолд” тодорхойгүй заасныг тодорхой болгох;

8.Хүчин төгөлдөр Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль болон Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд “хотын стандарт”-ын асуудлыг зохицуулсан. Тус стандарт буюу ойлгомжгүй байдлыг арилгахад чиглэсэн зохицуулалт тусгасан нь сайшаалтай. Гэвч үүнтэй холбогдуулан дагалдуулан боловсруулах хуулийн төслүүд, тухайлбал, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг анхаарах;

9.Хуулийн төслийн 30.2 дахь хэсэгт итгэмжлэлийн асуудал эрхэлсэн байгууллага нь төрийн захиргааны байгууллага байхаар тусгажээ. Хүчин төгөлдөр хуулийн төсөлд итгэмжлэлийн байгууллага гэсэн агуулгаар заасан байдаг.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.” гэж, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны зохих хүрээ, Ерөнхий сайд, сайдын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна.” гэж заасан. Өөрөөр хэлбэл төрийн захиргааны байгууллага буюу агентлагийг хуулиар байгуулж болох боловч энэ нь хуульд заасан дээрх шаардлагыг хангах эсэхийг судалж хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой тусгасны үндсэн дээр хуулийн төсөлд тусгах ёстой. Итгэмжлэлийн байгууллага болон итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуулийн нэр томъёоны хувьд ялгаатай бөгөөд үүнийг хуулийн төсөлд дахин нягталж тодорхой болгох эсхүл үзэл баримтлалд тусгах;

10.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх;” мөн хуулийн 10.1.3. дахь заалтын дагуу хуульд хаалттай мэдээлэл гэж зааж болох зохицуулалттай. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Хаалттай мэдээлэлтэй хуульд заасанд үндэслэл, журмын дагуу танилцаж, ашиглаж, ил болгоно.”, мөн зүйлийн 10.3 дахь хэсэгт “Хүнд хамаарах хаалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр хуульд заасан зорилго, нөхцөл, журмын дагуу ашиглана.” Гэж тус тус заасан. Иймд хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд хаалттай мэдээллийг ашиглахтай холбоотой зохицуулалтыг тодорхой тусгах;

10.Хуулийн төслийн 35.2 дахь хэсэгт “стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Төсвийн тухай хуулийн 46.2-т заасан журмын дагуу үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос стандартчилал, техникийн зохицуулалтын техникийн шинэчлэл, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зардлыг санхүүжүүлнэ.” гэж тусгасан байна. Энэ нь хүчин төгөлдөр хуульд байгаа зохицуулалт боловч Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох,

түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна.” гэж заасантай зөрчилдөхийг анхаарах.

## 2. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан үнэлсэн хийсэн болно.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Мөн тус хуулийн төслийг дагалдан боловсруулагдсан хуулийн төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт заасан дугаарлалт болон хуулийн төслийн заалтын байршилд тавигдах шаардлагыг хангасан байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

## 4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

| д/д | Шалгах асуулт  | Шаардлагыг хангасан эсэх  |
|-----|--|---|
| 1   | 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх          | Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.   |
| 2   | 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх  | Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно. |
| 3   | 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн | Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна.                              |

|   |   |  |
|---|---|--|
|   | нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх   |  |
| 4 | 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх | Тус хуулийн төслийг дагалдаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан тус тус боловсруулсан байна. |

- Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

| д/д | Асуулт   | Хариулт | Дүн шинжилгээ  |
|-----|--|---------|--|
| 1   | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх  | Тийм    | Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.   |
| 2   | Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх       | Тийм    | Энэхүү шаардлагыг хангасан байна.  |
| 3   | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх | Үгүй    | Энэхүү шаардлагыг хангасан байна.  |
| 4   | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх                   | Тийм    | Дүн шинжилгээний хүрээнд хуулийн төслийн зарим заалт өөр хоорондоо зөрчилдсөн байх тул залруулах шаардлагатай бөгөөд үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно.   |
| 5   | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх                    | Тийм    | Давхардсан агуулга бүхий зохицуулалт байхгүй.  |
| 6   | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх   | Тийм    | Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.   |
| 7   | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх  | Тийм    | Хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. <i>Жич: Нэмэлт оруулах зохицуулалтын талаар Зөвлөмж хэсэгт тусгасан.</i> |
| 8   | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх                                | Үгүй    | Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.   |
| 9   | Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх          | Тийм    | Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.  |

|    |  |      |   |
|----|--|------|---|
| 10 | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх   | Үгүй | Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.  |
| 12 | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх | Тийм | Хязгаарлалт нь Үндсэн хуульд заасан зарчимд нийсэн хэмээн дүгнэсэн.   |
| 13 | Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх   | -    | Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.   |
| 14 | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх  | -    | Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.  |
| 15 | Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх  | Үгүй | Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх хэмжээг хэрэгжүүлэх явцад хүнд суртал, авлигаас сэргийлэхэд чиглэсэн тодорхой зохицуулалт нэмэлтээр тусгах шаардлагатай гэж дүгнэж байна. |
| 16 | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.       | -    | Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан.   |

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдсөн зохицуулалт байхгүй, харин хууль зүйн техникийн хувьд хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах шаардлагатай зарим асуудал байна. Тухайлбал,

1.Хуулийн төслийн нэрийг өөрчилсөн талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой тусгаагүй байгаад анхаарч Хууль тогтоомжийн тухай хуулийн аргачлалд заасны дагуу Түүнчлэн хуулийн өслийн үзэл баримтлалын нэрийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр тусгаж, харин үзэл баримтлалдаа шинээр нэрлэх хуулийн нэрийг тусгайлан өөрчлөн тусгах талаар тусгахыг анхаарах;

2.Хуулийн төслийн бүтцийн хувьд талаас илүү хувь буюу ихэнх зохицуулалт нь байгууллагын тогтолцоо, эрх бүхий этгээдийн бүрэн эрхийн талаарх зохицуулалт байгааг анхаарч хуулийн төслийн зорилгод нийцүүлэн стандартчилал тохирол, техникийн зохицуулалтын үйл ажиллагааг одоо байгаагаас илүү процессжуулах, зохицуулалтын шинжтэй заалтуудыг нэмэгдүүлж, иргэн хуулийн этгээдэд болон хэрэгжүүлэх этгээдэд тодорхой болгоход анхаарах;

3.Хуулийн төслийн бүлгийн дарааллын дахин нягталж, стандартчилал тохирол техникийн зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой бүлгүүдийг эхэлж тусгах, дараа нь түүнийг хэрэгжүүлэх этгээдийн эрх үүрэг байгууллагын тогтолцоо, санхүүжилт, хариуцлага бусад зүйл гэсэн дарааллаар шинэчлэн тогтоох;

4.Шилжилтийн үеийн зохицуулалт шаардлагатай эсэхийг тухайлан анхаарах шаардлагатай. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах замаар зохицуулах боломжтойг анхаарах.

## **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ. Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд, хуулийн төсөлд ирүүлсэн санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах **Дүгнэлтийг** хийж, **Зөвлөмж** боловсрууллаа:

### **Дүгнэлт:**

**Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Гэвч зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Тухайлбал,

1.Хуулийн төслийн 21.2 дахь заалтад “Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандартчиллын баримт бичгийг заавал дагаж мөрдөнө.” гэж заасан байна. Хэдийгээр хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан стандартын талаарх тодорхойлолтод сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгжид төөрөгдөл, тодорхойгүй байдал үүсгэж байгааг өөрчлөх зорилгод хүрэхийн тулд энэхүү заалтыг тусгасан боловч энэхүү зохицуулалт тусгасан тохиолдолд үүнтэй холбогдуулан дагалдан боловсруулах хуулийн төслүүдийг сайтар олж тогтоох шаардлага үүсэхийг анхаарч тооцох шаардлагатай.

2.Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох боломж нээлттэй боловч хувийн хэвшлийн оролцоо, эрх хэмжээг нарийвчлан тодорхойлох зорилгод хүрэх зохицуулалт нь хуулийн төслийн 7.1.6 дахь заалтад хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах”;; мөн төслийн 7.1.7 дэх заалтад “стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээ хийх, энэ хуулийн 7.1.6-д заасан ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;” гэсэн заалтаар дамжих хэрэгжих боломжтой байна. Хувийг хэвшил рүү хандсан тэдний оролцоог хангасан зохицуулалт үүнээс өөр дэвшилтэт зохицуулалт байхгүй байгаад анхаарч, дээрх зохицуулалтаас гадна хуулийн төсөлд заасны дагуу байгуулах Зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн оролцоог хангах, шаардлагатай бол Худалдаа аж, үйлдвэрийн танхимын төлөөллийг оролцуулах замаар шийдвэрлэх боломжтойг анхаарах

3.Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоход зорилгод чиглэсэн зохицуулалт хангалтгүй байна. Иймд үзэл баримтлалд тусгагдсан тус зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

4.Хуулийн төслийн зохицуулалтууд нь бүхэлдээ тохирлын үнэлгээ болон тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгаж, техникийн зохицуулалт, заавал дагаж мөрдөх стандартуудын талаарх зах зээлд нийлүүлэгдэж хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхолд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны найдвартай байдал хангах зорилгод чиглэгдсэн байна гэж үзэхээр байна.

**Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээ боловсруулагдсан ойлгомжтой байна. Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, ойлгомжтой томъёолох шаардлагатай байна.

**Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийн зохицуулалт өөр Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна. Харин тус хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

### **Зөвлөмж**

Хуулийн төсөлд дараах агуулгын чанартай зохицуулалт нэмэх, тодруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Хуулийн төсөлд “Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандартчиллын баримт бичгийг заавал дагаж мөрдөнө.” гэж тусгасантай холбогдуулан дагалдан боловсруулах хуулийн төслүүдийг сайтар тогтоох ;

2.Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зорилгын хүрээнд хуулийн төсөлд заасны дагуу байгуулах Зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн оролцоог хангах, шаардлагатай бол Худалдаа аж, үйлдвэрийн танхимын төлөөллийг оролцуулах замаар шийдвэрлэх;

3.Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох.

Хуулийн төслийн шинэчлэн найруулсан байх бөгөөд дараах давхардал, хийдэл, зөрчил үүссэн байгааг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1.Хуулийн төсөлд Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн “төв байгууллага” гэж нэр томъёог хэрэглэсэн нь хууль батлагдсаны дараа хууль хэрэглээнд тодорхойгүй байдал үүсдэгийг анхаарч Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн төрийн захиргааны байгууллага гэсэн агуулгаар өөрчлөн тусгах;

2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн орон нутгийн хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, түүнчлэн мөн хуульд заасны дагуу нийслэлийн чиг үүрэгт стандарт хэрэгжүүлэх асуудал мөн харьяалагдаж байгааг анхаарч, аймаг, нийслэлийн стандартчлал тохирлын үнэлгээний газрын даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөхгүйгээр шууд томилохоор зарчмын өөрчлөлтийн талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгах;

3.Хуулийн төслийн тусгасан стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний дүрэм, журам, заавар, боловсруулах, батлах зохицуулалтыг эргэн харж, журмаар зохицуулах харилцааг аль болох хуулийн төсөлд тусгах замаар шийдвэрлэх, зайлшгүй шаардлагатай бол Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тусгайлан батлах журмын нэр, зохицуулах асуудлыг тодорхой тусгах;

4.Хуулийн төслийн стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах эрх олгох, цуцлах зохицуулалтыг аливаа зөвшөөрөл хэлбэрт оруулахаас зайлсхийж харин бүртгэлийн хэлбэрээр явуулж болохыг хуулиар зөвшөөрсөн тул Зөвшөөрлийн тухай хуулийн энэхүү зохицуулалтыг ашиглах;

5.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд хотын стандартын асуудлыг зохицуулсан. Тус стандарт буюу ойлгомжгүй байдлыг арилгахад чиглэсэн зохицуулалт тусгасан боловч үүнтэй холбогдуулан дагалдуулан боловсруулах хуулийн төслүүдийг анхаарах;

6.Хуулийн төсөлд итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байхаар тусгажээ. Итгэмжлэлийн байгууллага болон итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуулийн нэр томъёоны хувьд ялгаатай бөгөөд үүнийг хуулийн төсөлд дахин нягталж тодорхой болгох, эсхүл хуулийн төслийн үзэл баримтлалд тусгах;

7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хаалттай мэдээллийг хуульд заасан тусгаж болох ч хаалттай мэдээллийг ашиглахтай холбоотой зохицуулалтыг тодорхой тусгах.

Хуулийн төслийг боловсронгуй болгоход хууль зүйн техникийн хувьд анхаарах зарим асуудал болох

1.Хуулийн төслийн бүтцийн хувьд талаас илүү хувь буюу ихэнх зохицуулалт нь байгууллагын тогтолцоо бүрэн эрхийн талаарх зохицуулалт байгааг анхаарч хуулийн төслийн зорилгод нийцүүлэн стандартчилал тохирол техникийн зохицуулалтын үйл ажиллагааг илүү процессжуулах, зохицуулалтын шинжтэй заалтуудыг нэмэгдүүлж, иргэн хуулийн этгээдэд болон хэрэгжүүлэх этгээдэд тодорхой болгоход анхаарах;

2.Хуулийн төслийн бүлгийн дарааллын дахин нягталж, стандартчилал тохирол техникийн зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой бүлгүүдийг эхэлж тусгах, дараа нь түүнийг хэрэгжүүлэх этгээдийн эрх үүрэг байгууллагын тогтолцоо, санхүүжилт, хариуцлага бусад зүйл гэсэн дарааллаар шинэчлэн тогтоох;

